



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД ЭРҮҮЛ МЭНДИЙН- САЛБАРЫН ОРОЛЦОО



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

"ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ОРОЛЦОО"

Холбогдох утасны жагсаалт:

- Цагдаагийн шуурхай дуудлага – 102
- Нийслэлийн цагдаагийн түр хамгаалах байр: 107
- Хүүхдийн тусламжийн утас – 108 дугаар утас
- Хүчирхийллийн эсрэг төв – 96490505

Нэг Цэгийн Үйлчилгээний төвүүдийн утас:

- Баян-Өлгий аймаг НЦҮТ-7042102, 94442902
- Баянзүрх дүүргийн НЦҮТ-70150183
- Баянхонгор аймаг НЦҮТ-70442122
- Гэмтэл согог судлалын үндэсний төв НЦҮТ: 70180139
- Говь-Алтай аймаг НЦҮТ-98299111
- Дархан-Уул аймаг НЦҮТ-70378737
- Дорнод аймаг НЦҮТ-70584455
- Завхан аймаг НЦҮТ-80740740
- Хэнтий аймаг НЦҮТ-70563433
- Өмнөговь аймаг НЦҮТ-70532005
- Хөвсгөл аймаг НЦҮТ-70382121
- Хан-Уул дүүрэг НЦҮТ-88127821, 88049073, 89893773
- Сүхбаатар дүүргийн НЦҮТ - 94016601
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн НЦҮТ (жижүүрийн цагдаагийн утас) -93070949

Энд илэрхийлсэн үзэл санаа нь зохиогчдынх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй.

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд хэвлэв.

Боловсруулсан:

Д.Байгалмаа, Удирдахуйн болон Анагаах ухааны магистр, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Жендэр, хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтэн,

А.Өнөржаргал, Удирдахуйн магистр, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

Д.Одгэрэл, Удирдахуйн магистр, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэндийн албаны дарга

Б.Ганцэцэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэндийн албаны Нийгмийн ажилтан

“Монголын Хавдрын үндэсний зөвлөл” төрийн бус байгууллага

Хянасан:

Я.Буянжаргал, Анагаах ухааны магистр, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга

Дизайнер: Т.Ууганбаяр

Цаасны хэмжээ: 60x84 1/8

Хэвлэлийн хуудас: 11 х.х



БИТ ПРЕСС ХХК-д хэвлэв.

Утас (976) 11 311322

ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
СЭДЭВ 1.	
Хүний эрхийн үндсэн ойлголт	12
СЭДЭВ 2.	
Жендэрийн тухай ойлголт	18
СЭДЭВ 3.	
Жендэрт суурилсан хүчирхийлэл	25
СЭДЭВ 4.	
Гэр бүлийн хүчирхийлэл	35
СЭДЭВ 5.	
Хүчирхийлэлтэй тэмцэхэд эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтны оролцоо	46
СЭДЭВ 6.	
Хүчирхийлэлтэй тэмцэх салбар дундын хамтын ажиллагаа	60
СЭДЭВ 7.	
Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний арга зүй	64
СЭДЭВ 8.	
Хохирогчтой ярилцлага хийх арга техник	66
СЭДЭВ 9.	
Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдлийн түвшин	69
СЭДЭВ 10 .	
Тохиолдол/кейс/-ын удирдлагын төлөвлөгөө	73
СЭДЭВ 11.	
Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах бэлтгэл ажил	75
СЭДЭВ 12.	
Баримтжуулалт хийх, нотлох баримт бүрдүүлэх	79
СЭДЭВ 13.	
Холбон зуучлах үйлчилгээ	82

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын 2015 оны Ерөнхий Ассамблейгаар “Эх дэлхийгээ шинэчилье” 2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр” батлагдсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн 5 дахь зорилтод “Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, бүх төрлийн хүчирхийллийг эцэс болгох зорилт дэвшүүлсэн. Дэлхийн улс орон бүр хүчирхийллийг таслан зогсоох, шалтгаан, үр дагаврыг арилгах, хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Монгол Улс 2011 оны 2 сард Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль”, 2016 оны 12 сард “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, холбогдох хөтөлбөр, заавар, журам, стандарт батлаж, нийгмийн салбар, байгууллага бүр тодорхой үүрэг хариуцлага хүлээн харилцан уялдаатайгаар хамтран ажиллаж байгаа билээ.

Монгол Улсад НҮБХАС, ҮСХ-ны хамтран 2017 онд явуулсан “Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалт”-ыг тогтоох судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд, эмэгтэйчүүд амь насаа алдах, бэртэж гэмтэх явдал буурахгүй байна.

Хүчирхийллийг эцэс болгох, түүний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлстэй тэмцэх, сэргийлэхэд төр, засаг, нийгмийн бүхий л салбар, байгууллагууд, иргэд идэвхтэй хамтран ажилласнаар үр дүнд хүрэх боломжтой. Дээрх зорилтод хүрэхэд холбогдох салбар, байгууллага бүр үүрэг хүлээж, шийдвэр гарган ажилтнуудаа мэдлэгжүүлэх арга хэмжээ авч холбогдох гарын авлагыг гарган ашиглаж байна.

Хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн салбарын байгууллага, эмч, эмнэлгийн ажилтан, удирдлагууд ч тодорхой үүрэг, хариуцлага хүлээсэн бөгөөд энэ талаарх бүхий л бодлого, хэрэгжилтийн баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж байна. Энэхүү гарын авлагад хүчирхийлэл, түүний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс, гарах үр дагавар, авах арга хэмжээний талаарх мэдээллүүд багтсан бөгөөд тус гарын авлагыг эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, эмч, эмнэлгийн ажилтан бүр үйл ажиллагаандаа болон сургалт зохион байгуулахдаа ашиглах бүрэн боломжтой юм.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад өөрийн мэдлэг оюунаа бусдад түгээх харамгүй сэтгэлээр дэмжлэг үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилтан, мэргэжилтэн, судлаач Та бүхэндээ талархаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ техник, санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан НҮБ-ын Хүн амын сангийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

НОМЫН ЦАГААН БУЯН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

НҮБ-ын 2015 оны Ерөнхий Ассамблейн баталсан “Эх дэлхийгээ шинэчилье” 2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн үндсэн зарчим нь “Нэг ч хүнийг тусламж, үйлчилгээнээс орхигдуулахгүй байх” юм.

Тус хөтөлбөрийн 5 дахь зорилтод “Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, **бүх төрлийн хүчирхийллийг эцэс болгох**” хэтийн зорилтыг дэвшүүлсэний дагуу дэлхийн улс бүрт гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдыг илрүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх зэрэг нийгмийн олон салбарын хамтарсан тусламж, үйлчилгээг зохион байгуулж байна.

Монгол Улс 2011 онд “Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль”, 2016 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” батлан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль эрхзүйн орчны шинэчлэл хийж, нийгмийн салбар бүр тодорхой үүрэг хариуцлага хүлээн мөрдөж байна.

Монгол Улсад НҮБХАС, ҮСХ хамтран 2017 онд явуулсан “Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалт”-ыг тогтоох үндэсний судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр байгаа нь тогтоогдсон. Иймээс хүчирхийллийн шалтгаан, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлтэй тэмцэх, сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд, эмэгтэйчүүд амь насаа алдах, бэртэж гэмтэх явдлыг таслан зогсоох ажлыг салбар бүр хуулиар хүлээсэн үүргийн дагуу үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байгаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй нэг салбар дангаар тэмцэх нь үр дүн муутай юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хууль, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, засаг захиргааны нэгжүүд болон төрийн бус байгууллагууд зэрэг олон салбар, мэргэжилтнүүдийн хүлээх үүргийг тодорхой болгосонтой холбоотойгоор хүний эрх, жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар суурь мэдлэг, нэгдсэн ойлголтыг салбар бүр, ялангуяа эрүүл мэндийн салбарын ажилтан нэгдсэн ойлголттой байх зайлшгүй шаардлага байна.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 15, 27 дугаар зүйлд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон эмч, эрүүл мэндийн ажилтны чиг, үүргийг тодорхойлж, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдаж байх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх, нууцыг хадгалах үүргийг хүлээлгэн хуульчилсан.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх,

эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтыг зохион байгуулахыг тус хуулиар үүрэг болгосон.

Хамтарсан багийн гишүүд, эмч, эмнэлгийн ажилтан, багш, хуульч, сэтгэл зүйчид, засаг захиргааны ажилтан, удирдах ажилтанд зориулсан сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагууд зохион байгуулсаар ирсэн ч гэр бүлийн хүчирхийллээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэх, эрт шатанд нь илрүүлэх, таслан зогсооход эмч, эмнэлгийн ажилтан бүрийн ойлголт, мэдлэгийг үе шаттайгаар сайжруулах, сургалт зохион байгуулах, шаардлагатай гарын авлага материалаар хангах асуудал нь эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудал болж байна.

Хүний эрх, жендэр болон жэндэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголтууд, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход эрүүл мэндийн ажилтнуудын гүйцэтгэх үүрэг, сургалтын зохион байгуулалт, сургалтын агуулга, арга зүй бүр өөр өөр байгаатай холбоотойгоор нэгдсэн нэг ойлголт өгөх агуулга бүхий цөм сургалтын агуулгыг боловсруулж, эмч, эмнэлгийн ажилчдын хүртээл болгох зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулав.

Сургалтын гарын авлагын зорилго:

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар эрүүл мэндийн удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэний мэдлэг, хандлагыг зөв төлөвшүүлэх;

Сургалтын зорилт:

Мэдлэг олгох: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн талаарх ойлголт, түүнийг илрүүлэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйлчилгээний үндсэн зарчим, үзэл баримтлалын талаар нэгдсэн ойлголт өгөх;

Хандлагыг өөрчлөх: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан, хүний эрхэд суурилсан үйлчилгээг хохирогчдын хувь хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн, нууцлалыг хадгалсан, чанартай, сэтгэл гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэх хандлага төлөвшүүлэхэд нөлөөлөх;

Ур чадвар эзэмшүүлэх: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээг хууль эрхзүйн хүрээнд үзүүлэх, батлагдсан маягыг зөв хөтлөх, баримтжуулах, холбон зуучлах, эргэх холбоо тогтоох, нөхөн сэргээх үйлчилгээг харилцан уялдаатай, зохион байгуулалттайгаар үзүүлэх практик ур чадварыг эзэмшүүлэх.

Нэр томъёоны тайлбар

“жендэр” гэж нийгмийн хүйс буюу эрэгтэй, эмэгтэй хүний биологийн ялгаа болон нийгмийн үүргийг ялган салгаж ойлгохын тулд хэрэглэх болсон

нэр томьёо бөгөөд нийгмийн зүгээс хүлээлгэсэн үүрэг, үнэлэмжийн ялгаатай байдал, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;

“жендэрийн тэгш эрх” - эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд хөгжлийн үр шим, хариуцлагыг хуваарилах шударга, хууль цааз тогтоосон байхыг хэлнэ. Энэ үзэл санаа нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ялгавартай хэрэгцээ, чадавх, боломжийг хүлээн зөвшөөрч тэдгээр ялгааг тодорхойлж, ач холбогдол өгч, хүйсийн хооронд дахь тэгш бус байдлыг засч залруулахыг;

Жендэрийн тэгш байдал – эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралдаа эн тэгш үнэлэгдэж, хөгжлийн явцад оролцох, үр шимийг хүртэх тэгш боломжоор хангагдаж, хүйсийн ялгаваргүйгээр эдгээрийг эдлэх бололцоо, хүртэх боломж нь тэгш байхыг;

“жендэрийн хэвшмэл ойлголт” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;

“жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

“жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт” гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг;

“жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт” гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг;

“бэлгийн дарамт” гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг;

“жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг;

“гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

“гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг;

“гэрлэгчид” гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг;

“гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг;

“төрлийн хүн” гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

“садангийн хүн” гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг;(Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт)

“Гэр бүлийн хүчирхийлэл” гэж гэр бүлийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлд заасан аль нэгэн этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг;(ГБХТТХ-ийн 5.1.1.дэх заалт)

“гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;

“нэг цэгийн үйлчилгээ” гэж хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг;

“гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” /цаашид “хамтарсан баг” гэх/ гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг;

“түр хамгаалах байр” гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг;

“хамтран амьдрагч” гэж гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг;

“холбон зуучлах үйлчилгээ” гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох

төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг;
“хүчирхийллийн болзошгүй эрсдэл” гэж гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг.

“хүчирхийлэл” гэж санаатай, зохион байгуулалттай, олон жилийн түүхэн хөгжлийн явцад бэхжин институтчлэгдсэн соёл иргэншил, итгэл үнэмшлээс үүдэлтэй, өргөн тархацтай нийгмийн эрүүл мэндийн асуудал бөгөөд энэ нь хувь хүн, гэр бүл, нийгмийн тодорхой бүлэг буюу хэсэг хүмүүсийн бие махбодь, сэтгэл санаанд цочрол гэмтэл учруулах, амь насыг нь бүрэлгэх зэрэг нийгэм эдийн засгийн хөгжилд асар их хор хохирол дагуулдаг сөрөг зан үйлдэл юм.

Хүчирхийллийн илрэх хэлбэрүүд

Хүчирхийллийн илрэх хэлбэрт биемахбодийн, сэтгэлзүйн, бэлгийн, оюун санааны, эдийн засгийн, эрх мэдлийн, айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгих зэрэг үйлдлүүд багтдаг.

Хүчирхийллийг дараах үндсэн 3 категорит авч үзнэ. (ДЭМА.49.25.):

- Хувь хүн өөрийгөө хүчирхийлэх
- Хүн хоорондын хүчирхийлэл
- Нийгмийн бүлэг хоорондын хүчирхийлэл

“хувь өөрийгөө хүчирхийлэх” гэж өөрийн бие махбодийг гэмтээх, амиа хорлох тухай бодох, төлөвлөх, оролдлого хийх, амиа бүр мөсөн егүүтгэхийг;

“хүн хоорондын хүчирхийлэл” гэж хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн хоорондын харилцааг хэлнэ. Энэ нь гэр бүлийн болон дотны харилцаатай хүн хоорондын эсхүл нийгмийн бүлэг, үл таних хүн хоорондын хүчирхийлэл хэмээн хоёр дэд категорит хуваан авч үзэхийг;

“гэр бүлийн болон дотны харилцаатай хүмүүс хоорондын хүчирхийлэл” гэж гэр бүлийн гишүүд, эцэг эх хүүхэд, төрөл садан, хамтран амьдрагч, салсан хүмүүс хоорондын харилцааг авч үзнэ. Энэ хүчирхийлэл нь ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг.

“нийгмийн бүлэг хоорондын хүчирхийлэл” гэж гэр бүлийн болон дотно харилцааны бус үл таних, эсхүл хувь хүн, бүлэг хүмүүс хоорондын тухайлбал; өсвөр нас, залуучуудын, бэлгийн дарамтлал, хүчин, улс төр, шашны зэвсэгт мөргөлдөөн, дайн, терроризм, арьс өнгө, хүйсийн ялгаварлал, “хүйс тэмтрэх” гэх мэт өргөн хүрээний институтчлэгдсэн харилцааг хэлнэ¹;

“болзошгүй хүчирхийлэл” гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг; (ГБХТТХ-ийн 5.1.2)

1 Дэлхийн эрүүл мэндийн ассамблей 45. 25-р тогтоол Женев 1996, 2002

“бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан гэмтэл” гэдэгт “амь биед нь санаатай гэмтэл учруулсан буюу хараа сонсголгүй болгосон, эрхтнээс хагацуулсан, ажиллагаагүй болгосон, хөдөлмөрийн чадварыг нэг мөсөн алдагдуулсан” гэмтлүүд багтана. (Эрүүгийн хуулийн 96-р зүйлийн 1-д заасан зүйл)

“хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн, эцэг эх, асран хамгаалагч, хүмүүжүүлэгчийн зүгээс санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас эрүүл мэнд, хөгжил, биемахбод сэтгэл санаанд хор хохирол учруулсан үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл, бие махбодын шийтгэл сэтгэл санааны дарамтыг;

“бэлгийн хүчирхийлэл” гэж хүчин, гэрлэгсдийн, болзооны, ураг төрлийн(хүүхдийн), ажлын байрны, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийг;

“хүчиндэх” гэж гэмт этгээд хурьцал үйлдэх, өөрийн санаа зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хохирогчийн хүсэл зөвшөөрөлгүйгээр, түүний эсэргүүцэл, зоригийг няцааж, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, эсвэл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулах замаар хүчирхийлэн хурьцал үйлдэхийг;(УДШ 1989,13-р тогтоол)

“...гэр бүлийн хүчирхийлэл...”-ийн **“бие махбодын хэлбэр”** гэдгийг ГБХТТХуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд нөгөө этгээдээ өөрийн эрхшээлд байлгах, гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох зорилгоор хүч хэрэглэн биед нь халдсаныг;

“сэтгэл санааны хэлбэр” гэдгийг ГБХТТХуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдээ айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгих, доромжлох,нэр төр алдар хүндийг гутаах, ах дүү, хамт олноос нь тусгаарлах, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийлгэхийг албадах, тулган шаардах, зэргээр үг яриа, үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтанд оруулсныг;

“бэлгийн хэлбэр” гэдгийг ГБХТТХуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдийнхээ бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, хүүхдээ бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан зэрэг үйлдлийг;

“эдийн засгийн хэлбэр” гэдгийг ГБХТТХуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарласныг;

“нөхөн сэргээх үйлчилгээ” гэж үйлчлүүлэгчийг хүчирхийлэлд дахин өртөх эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, таслан зогсоох нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх, чадавхижуулах, хүчирхийллийн улмаас хохирсон бие махбодь, сэтгэлзүй, эрхзүйн хохирлыг нөхөн сэргээж хэвийн байдалд нь эргэн ортол нь нөхөн сэргээх урт хугацааны эрүүл мэндийн, сэтгэлзүйн, хууль эрхзүйн, нийгмийн, халамжийн үйлчилгээг;

“түр хамгаалах байр” гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулан, ГБХТТХ-д заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг; (ГБХТТХ-ийн 5.1.5.)

“итгэмжлэгдсэн төлөөлөгч” гэдэг нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон аливаа хэрэг, маргаанд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах үүрэг бүхий, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас итгэмжлэгдсэн этгээд байна.

“шинжээч эмч” гэж хохирогчийн биеийн гэмтлийн байдлыг тогтоох эрх бүхий хүний их эмчийг;

“шинжээч эмчийн шинжилгээ” гэж шүүх эмнэлгийн дүгнэлтэнд нотлох баримтын шаардлага хангахуйц хохирогчийн биеийн гэмтлийн байдлыг тогтоох эмчийн үзлэг, шинжилгээг;

“гэмтлийн байдал” гэж шинжээч эмч хохирогчийн биед үзлэг шинжилгээ хийж, эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний удирдамжийн хүлээн авах менежменийн заасан шинж тэмдгээр улаан шар,ногоон, цагаан гэсэн ангилал тогтоох, нарийн мэргэжлийн эмчийн магадлагааг;

“мэдүүлэг авах ярилцлага” гэж нэг цэгийн үйлчилгээнд ирсэн хохирогчоос нотлох баримт мэдээлэл цуглуулах, нийгмийн ажилтан ба цагдаагийн ажилтан журмын дагуу зохих мэргэжлийн түвшинд ярилцлага авахыг;

СЭДЭВ 1. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгчдийн хүний эрхийн суурь ойлголтын талаарх мэдлэгийг нэмэгдүүлнэ.

Үндсэн ойлголт:

- ✓ Хүний эрх гэж юу вэ?
- ✓ Хүний эрхийн суурь зарчмууд

Олгох мэдлэг ур чадвар:

- ✓ Хүн, хүний эрхэм чанар, амьдрахын утга учрыг таниулах
- ✓ Хүний эрхэм чанар нь хүний эрхийн үндэс болохыг танилцуулах
- ✓ Хүний эрхийн суурь зарчмуудтай танилцах
- ✓ Ялгаварлалт, дарамт, хараат байдал, шударга бус байдлыг эсэргүүцэх,
- ✓ Хүний эрх, эрх чөлөөг дур зоргоос ялган ойлгох

Хүрэх үр дүн:

- ✓ Хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөөний талаар нэгдсэн ойлголтод хүрнэ.
- ✓ Ялгаварлан гадуурхалт, доромжлол, дарамт, хүчирхийлэл нь хүний эрхэм чанарт халддаг, хүний эрхийн зөрчил болохыг ухаарна.

Хичээлийн агуулга:

- ✓ Хүний эрхэм чанар, үндсэн шинжүүд
- ✓ Хүний эрх, түүний суурь зарчмууд
- ✓ Хүний эрх, эрх чөлөө ба хариуцлага
- ✓ Хүчирхийлэл дарамтаас ангид байх, халдашгүй байх

Гол санаа:

- ✓ Хүн бүрт өөрөөс нь салгаж үл болох эрхэм чанар бий гэдэг нь хүн болж төрснийхөө хувьд хүн бүр адил үнэ цэнэтэй гэсэн үг.
- ✓ Хэн байхаас нь үл хамааран хүн бүрийн хүний эрхэм чанарыг хүндлэх ёстой.
- ✓ Хүн бүр тодорхой үндсэн эрх, эрх чөлөөг эдэлнэ. Хүний эрхийг эдлэх цорын ганц нөхцөл нь хүн байх явдал юм.
- ✓ Хүн бүрийн эдлэх эрхүүдэд хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид, хараат бус, халдашгүй амьдрах эрх багтдаг.
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэл бол хүний эрхийн ноцтой зөрчил
- ✓ Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах нь төрийн үүрэг юм.
- ✓ Хүн бүрийн аюулгүй, хараат бус, халдашгүй байдлыг анхаарч, хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн үйлчилгээг хүргэх шаардлагатай.

Хичээлийн явц:

Уг сэдэв нь нийт 3 алхамтай. Хэрэглэгдэх арга нь эргэцүүлэн бодох дасгал хэлэлцүүлэг, лекц мэдээлэл байна.

Алхам 1: Хүний эрхэм чанар, үндсэн шинжүүдийн талаар мэдээлэл өгөх

Алхам 2. Хүний эрх гэж юу вэ? талаар хэлэлцүүлэг өрнүүлэх. Оролцогчдод өөрийнхөө эрхийн талаар бодох боломж олгоно. Хэлэлцүүлэг дасгалын дараагаар хүний эрхийн тодоройлолт болон хүний эрхийн суурь ойлголтын мэдээллийг дахин өгнө.

Алхам 3. Хүний эрхийн суурь зарчмууд мэдээлэл өгөх

Алхам 1.

Хүний эрхийг хамгаалахад суурь болон ашиглагдаж буй хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөөний талаарх төсөөлөл, ойлголт, мэдлэгийн талаар оролцогчдод мэдлэг олгоно. Хүн болж төрсний хувьд хүн бүр ижил үнэ цэнэ, адил хүндэтгэлийг эдлэх төрөлхөөс заяасан эрхтэй. Хэн байхаас нь үл хамааран хүн бүрийн эрхэм чанарыг хүндлэх ёстой.

Хүн бүрт эрхэм чанар гэдэг нь хүн бүрийн амьдрал адилхан үнэ цэнэтэй гэсэн үгнээс үүдэн хүндлэлийн тухай ойлголт гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, хүнийг хүндлэх гэж юу вэ гэсэн асуултад хариулах шаардлагатай болно. Хүндлэлийг ерөнхийд нь хоёр хувааж болно:

1/ Хүлээн зөвшөөрөх хүндлэл

2/ Үнэлэх хүндлэл.

Бид хүмүүсийг зан чанар, бүтээсэн зүйлийг нь үнэлж хүндэлдэг. Харамсалтай нь, зарим хүн ийм хүндлэл огт хүлээдэггүй. Хүлээн зөвшөөрөх хүндлэл нь хүнийг хүнийх нь хувьд хүндлэх тухай норматив ойлголт юм. Энэ нь хүний эрхэм чанар гэх ойлголтын цөм утгыг илэрхийлдэг. Хүлээн зөвшөөрөх хүндлэл гэдэг бол хүн бүрийг хэн байхаас нь үл хамааран хүнийх нь хувьд хүндлэх буюу хүний эрхэм чанартай гэдгийг нь хүлээн зөвшөөрч хүндлэх тухай юм. Жишээлбэл, 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршлын хамгийн эхэнд "Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүдийн төрөлх эрхэм чанар болон салшгүй эрхүүдийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дээрх эрх чөлөө, шударга ёс, энх тайвны үндэс..." гэж бичсэн байдаг.

Хүний эрхийн тухай олон улсын гэрээнүүд болон ардчилсан улсуудын үндсэн хуулиудад хүнийг хүнийх нь хувьд хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, эвлэлдэн нэгдэх, хувийн амьдрал халдашгүй байх зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх талаар зааж, хамгаалах механизмыг тогтоосон байдаг.]²

2 "Хүний эрхэм чанар (human dignity)" нийтлэл 2015, О.Мөнхсайхан, МУИС-ийн Хуульзүйн сургуулийн дэд профессор, хуульзүйн доктор

Монгол Улсын Үндсэн хуулинд ч ялгаагүй хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх эрхтэйг тунхаглаж, хэнд боловч хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглосон.³ 2013 онд Хуульчдын анхдугаар их хурлаас баталсан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-д хүн бүрийн эрхэм чанарыг хүндлэх нь хуульчдын баримтлах үндсэн зарчим гэж зааж, хууль зүйн хувьд албан ёсны хэрэглээнд оруулсан.

Хүний эрхэм чанарын үндсэн шинжүүд

Хүний эрхэм чанар нь дараах 4 үндсэн шинжтэй:

1. *Заяамал*: Хүн болж төрснийх нь хувьд угаас заяагдсан төрөлх чанар болохоос хэн нэгний, аль нэг институци, байгууллагын олж тогтоосон, эсвэл олгодог, зөвшөөрдөг зүйл биш.

2. *Түгээмэл*: Хүний эрхэм чанар нь үндэс угсаа, нийгмийн гарал, нас, хэл, хүйс, боловсрол, гэр бүлийн байдал, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, итгэл үнэмшил, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл зэрэг төрөлхийн болон бусад байдлаас үл хамааран хүн бүрт адил.

3. *Салшгүй*: Хүний оршихуйгаас урган гардаг тул хэзээ ч, ямар ч тохиолдолд салгаж, бас халдаж болдоггүй. Хэнд ч хүнлэг бус, хэрцгий хандаж, зодож, тарчлааж болохгүй.

4. *Хэмжигдэшгүй*: Хүн бүр “хүн” учраас адил үнэ цэнэтэй. Олон, цөөн, баян, ядуу, олонхийн санаа бодол, сайн муугийн үнэлэмж зэрэг ямар ч үзүүлэлтээр үл хэмжигдэнэ.

Хүний эрхэм чанар бол хүний эрх, эрх чөлөөний үндэс юм. Хүний эрхэм чанар хөндөгдөж байвал бид бүрэн утгаараа хүн шиг амьдарч чадахгүй байна гэсэн үг. Тиймээс хүний эрхийг эдлэх цорын ганц нөхцөл нь хүн байх явдал болно. Хүний эрхийг эдлүүлэхгүй байх нь хүн гэдгийг нь үгүйсгэж байгаа хэрэг мөн.

Алхам 2. Хүний эрх.

Оролцогчдоос “Хүний эрх гэж чухам юу вэ?” гэдэг асуултыг асууж, оролцогчдын санааг самбарын цаасан дээр буулгана. Энэ нь оролцогчдын хүний эрхийн талаар ойлголт мэдлэгийг ажиглах зорилготой. Оролцогчдын санааг самбарын цаасан дээр буулгасны дараа чиглүүлэгч дараах дүгнэлтийг хийнэ.

Чиглүүлэгчийн мэдээлэл:

Чиглүүлэгч дээрх сэдвийн хүрээнд дараах гол ойлголтуудыг оролцогчид өгнө. Үүнд:

- Хэн байхаас үл хамааран хүн бүрт байдаг, угаас заяагдсан төрөлх чанар

³ Монгол Улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйл, 16.1.13 дахь заалт, 1992 он.

- Хүн бүрт өөрөөс нь салгаж үл болох эрхэм чанар бий, тэр нь хүний эрхийг үндэс болдог.
- Хүний эрх бол таныг хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа өөрөөр хэлбэл хүн бүрийг эрхэм чанараа хадгалан, нэр төртэй, үнэ цэнэтэйгээр амьдрахад зайлшгүй шаардлагатай стандарт юм.
- Хүний эрхийг эдлэх цорын ганц нөхцөл нь хүн байх. Ямар нэгэн ялгаатай байдлыг үл харгалзан ямар ч ялгаварлалгүйгээр эрхээ эдлэх ёстой.

1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Францын Парис хотод болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд **ХҮН БҮР** дараах эрхтэйг тунхаглан баталсан.

1. Амьд явах эрхтэй
2. Өв залгамжлах эрхтэй
3. Өмчлөх эрхтэй
4. Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих эрхтэй
5. Гадаадад явах, оршин суух эрхтэй
6. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй
7. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй
8. Сурч, боловсрох эрхтэй
9. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй
10. Улс төр, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй
11. Тайван жагсаал хийх эрхтэй
12. Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй
13. Өргөдөл, гомдол гаргах эрхтэй
14. Шашин шүтэх, эс шүтэх эрхтэй
15. Сонгох, сонгогдох эрхтэй
16. Эд, мөнгөний тусламж авах эрхтэй
17. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхтэй
18. Шударга шүүхээр шүүлгэх эрхтэй
19. Сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй
20. Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй
21. Үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй
22. Мэдээлэл хийх, хүлээн авах эрхтэй
23. Хувийн аж ахуй эрхлэх эрхтэй
24. Хууль зүйн туслалцаа авах эрхтэй
25. Төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй
26. Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхтэй
27. Түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй

Алхам 3: Хүний эрхийн суурь зарчим

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсан хүний эрхийн суурь зарчмуудыг урьдчилан судалж танилцуулга хийнэ.

Хүний эрхийн суурь 6 зарчим байдаг бөгөөд бүх эрх хоорондоо салшгүй холбоотой, хуваагдашгүй, цогц, харилцан хамааралтай. Нэг эрх зөрчигдөхөд л бусад эрх хөндөгддөг тул эрэмбэ, шатлалгүй.



Зураг 1. Хүний эрхийн суурь зарчмууд

Заяамал: Хүний эрх нь төрөлх, заяамал шинжтэй. Бүх хүн нас, хүйс, яс үндэс, гарал үүсэл, арьсны өнгө, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хэл, шашин шүтлэг, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харъяалал болон улс төрийн үзэл бодол зэргээс үл хамааран ижил хүндлэл хүлээнэ.

Түгээмэл: Хүний эрх нь хүн бүрт хамаатай. Хүний эрх түгээмэл байна гэдэг нь хэн нэгний төрөлх болон бусад байдлаас үл шалтгаалан бүх хүнд хамаатай байна гэсэн утга агуулна.

Салшгүй: Хүн оршин байсан цагтэрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй. Эрхийг ямар ч нөхцөл, шалтгаанаар хүнээс ангид гэж үзэж болохгүй. Хэн ч өөрийн эрхийг алдах учиргүй. Зөвхөн хүний эрхүүд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд түүнийг хязгаарлаж болно. Онцгой нөхцөл байдалд хуулиар хязгаарласан болон гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсоноос бусад тохиолдолд тухайн хүнээс булааж үл болох салшгүй шинжтэй. Энэ тохиолдолд ч хүний салшгүй эрх болох амьд явах, халдашгүй амьдрах, эрх чөлөөтэй байх эрхийг хөндөж үл болно.


Хуваагдашгүй, шатлалгүй: Хүний бүх эрх ижил үнэ цэнэтэй. Нэг эрх нь нөгөө эрхээс чухалд тооцогдох, дээгүүр тавигдах ёсгүй. Нэг эрхийг давууд үзэх нь бусад эрхийг үгүйсгэх нөхцлийг бүрдүүлдэг. Бүх эрхүүд нь ижил ач холбогдолтой, адил тэнцүү шинж чанартай учраас ижил түвшинд хамгаалагдах, хангагдах ёстой.

Харилцан уялдаатай: Хүний эрхүүд нийлээд нэг цөм болж байдаг. Тэдгээр нь өөр хоорондоо харилцан хамааралтай, уялдаа холбоотой. Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүх хүрээнд хамаардаг. Хүний эрхийн зөрчлүүд нь харилцан холбогдсон байдаг тул нэг эрхийг зөрчигдсөнөөр бусад эрх мөн хязгаарлагддаг. Үүнтэй адил хүний аль нэг эрхийг хангах нь хүний бусад эрхийг хангахад мөн дэмжлэг болж байдаг.

Үл ялгаварлах: Хүн бүр арьсны өнгө, яс үндэс, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, гэрлэлтийн болон бусад байдлаас үл хамааран ямар ч ялгаварлалгүйгээр эрхээ эдлэх ёстой.

Хүний эрхийг хангах төрийн үүрэг

Хүний эрхийг баталгаатай хангахын тулд хүндэтгэл, хамгаалал, дэмжлэг, хангамж зайлшгүй шаардлагатай болдог. Төрөөс хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах хариуцлага хүлээдэг.



Зураг 2. Хүний эрхийг хангах төрийн үүрэг, хариуцлага

СЭДЭВ 2. ЖЕНДЭРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгчдийн жендэрийн талаарх суурь ойлголт мэдлэгийг нэмэгдүүлнэ.

Үндсэн ойлголт:

- ✓ Жендэр
- ✓ Жендэр хүйсийн ялгаа
- ✓ Жендэрийн тэгш байдал
- ✓ Жендэрийн хэвшмэл ойлголт
- ✓ Жендэрийн ялгаатай үнэлэмж
- ✓ Жендэрийн ялгаварлан гадуурхалт
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэл

Олгох мэдлэг, ур чадвар:

- ✓ Хүйс ба жендэрийн ялгаатай байдлыг тодорхойлох
- ✓ Жендэрийн үзэл баримтлалын талаар нэгдсэн ойлголттой болох
- ✓ Жендэрийн ялгаварлан гадуурхалтыг бий болгодог, бэхжүүлдэг нийгмийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаанд хэрхэн нөлөөлдгийг ойлгох
- ✓ Жендэрийн ялгаатай үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хандлага, зан үйл, сонголт, шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлдгийг таних

Хүрэх үр дүн

- ✓ Жендэрийн талаарх хэвшсэн ойлголт, төсөөллөө эргэн харж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай үнэлэмж, байр суурь, үүрэг хариуцлагаас үүдэлтэй дарамт, ялгаварлан гадуурхалт, эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан болдгийг ойлгоход нь дэмжлэг үзүүлэх
- ✓ Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд жендэрийн тэгш байдлыг хангах нь чухал болохыг ойлгоно.

Хичээлийн агуулга:

- ✓ Хүйс ба жендэрийн ялгаа
- ✓ Жендэрийн тэгш байдал ба жендэрийн мэдрэмж
- ✓ Жендэрийн хэвшмэл ойлголт ба жендэрийн ялгаатай үнэлэмж
- ✓ Жендэрийн тэгш бус байдал ба ялгаварлан гадуурхалт

Гол санаа:

- ✓ Хүйс ба жендэр нь ялгаатай ойлголт, Хүйс нь эрэгтэй, эмэгтэй хүний биологийн ялгааг илэрхийлдэг, Хүйсийн ялгаа нь генээр тодорхойлогддог, нийтлэг, үл өөрчлөгдөх чанар

- ✓ Жендэр нь нийгмийн хүйс буюу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд юу хийх, ямар байр суурь эзлэх, биеэ хэрхэн авч явах талаарх нийгмийн байр суурь, үүрэг хариуцлага, нийгмээс бий болгосон хүлээлт юм.
- ✓ Хүний биологийн болон нийгмийн ялгаа нь ялгаварлагдах үндэслэл болохгүй. Бид өөрсдөө зохиомол ялгааг бий болгож байгаа нь хүмүүсийн дунд эрх мэдлийн тэгш бус харилцааг үүсгэж байна.
- ✓ Жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөх хүчин зүйлийн нэг болно.
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд тэгш, тэнцвэртэй байдлыг бий болгохгүйгээр таслан зогсоох боломжгүй.
- ✓ Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд тэгш байдал, эрх мэдлийн тэнцвэр бий болгосноор жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх боломжтой.

Хичээлийн явц:

Уг сэдэв нь нийт 2 алхамтай. Хэрэглэгдэх арга нь эргэцүүлэн бодох дасгал хэлэлцүүлэг, лекц мэдээлэл байна.

Алхам 1: Жендэр гэж юу вэ? Оролцогчдын ойлголтыг тодруулах, жендэр хүйсийн ялгаа болон жендэрийн тухай ойлголтоо нэгтгэх

Алхам 2: Жендэрийн тэгш байдал болон жендэрээс үүдэлтэй гарч байгаа асуудлуудын талаар ярилцах, жендэрийн ялгаварлан гадуурхалт болон жендэрт суурилсан хүчирхийллийн талаар нэгдсэн ойлголттой болох

Алхам 1. Хүйс ба Жендэр:

Жендэр гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ. (Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 4.1.1)

Хүйс нь байгалиас заяасан, үл өөрчлөгдөх биологийн ялгааг илэрхийлдэг. Хүйсийн ялгаа нь генээр тодорхойлогддог, түгээмэл, нийтлэг зүй тогтолтой, үл өөрчлөгдөх чанар юм.

Жендэр нь нийгмийн хүйс буюу эрэгтэй, эмэгтэй хүний биологийн ялгаа ба нийгмийн үүргийг ялган салгаж ойлгохын тулд хэрэглэх болсон нэр томъёо бөгөөд нийгэмд хүмүүсийн хүлээсэн үүрэг хариуцлага, тулгарч буй саад бэрхшээл, хүртэж буй боломж бололцоог нь дүгнэн шинжлэх нийгэм, эдийн засаг, улс төрийн шинжтэй хувьсах хэмжигдэхүүн бөгөөд

нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүйн байршил, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэхчлэн олон үзүүлэлттэй харилцан хамааралтай байдаг.

2.1. Жендэр ба хүйсийн ялгаа

Хүйс \ биологийн хүйс\	Жендэр \ нийгмийн хүйс\
<ul style="list-style-type: none"> Биологийн ялгааг тодорхойлдог. 	<ul style="list-style-type: none"> Нийгмийн үүрэг, хариуцлага, байр, суурийн ялгаатай байдлыг тодорхойлдог.
<ul style="list-style-type: none"> Төрөлхийн/байгалиас заяагдсан үл өөрчлөгдөх чанартай байдаг. 	<ul style="list-style-type: none"> Олдмол/нийгмээс суралцдаг, оноодог, хуваарилдаг, цаг хугацааны хувьд хувиран өөрчлөгддөг.
<ul style="list-style-type: none"> Өөрчлөгдөхгүй, байнгын тогтсон шинжүүдтэй 	<ul style="list-style-type: none"> Өөрчлөгддөг, хувьсах хэмжигдэхүүн
<ul style="list-style-type: none"> 2 туйлт ойлголт (эрэгтэй, эмэгтэй) 	<ul style="list-style-type: none"> Асар олон талт ухагдахуун Өөр өөр соёл иргэншлийн хувьд ялгаатай байдаг.
<ul style="list-style-type: none"> Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн хувьд ижил 	<ul style="list-style-type: none"> Ижил хүйсийн хүмүүсийн дунд ч ялгаа байдаг.
<ul style="list-style-type: none"> Түгээмэл, бүх улс оронд адилхан 	<ul style="list-style-type: none"> Нийгэм, соёл бүрт харилцан адилгүй өөр байдаг.

2.2. Жендэрийн хэвшмэл ойлголт ба жендэрийн үүрэг

Жендэрийн хэвшмэл ойлголт

Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг жендэрийн хэвшмэл ойлголт гэнэ.

Жендэрийн ялгаатай үнэлэмж нь эрэгтэй, эмэгтэй, охин, хөвгүүн болон тодорхой бүлгийн хүмүүсийн үүрэг, хариуцлага, тэдний хувьд “зөв”, “зүйтэй” хэмээн тооцогдох зан үйл, хийж болох болон болохгүйн хязгаарлалтыг тодорхойлдог. Жишээ нь: эрэгтэй хүн эмэгтэйг оройн хоолонд урих, хоолны төлбөрийн тасалбарыг эрэгтэйд өгөх, эрэгтэй хүн онгоцны буудал дээр хүүхдийнхээ живхийг солих болоход ийм өрөөнүүд зөвхөн эмэгтэй бие засах өрөөнд л байдаг гэх мэт.

Жендэрийн ялгаатай үнэлэмж нь нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтоос үүдэлтэй. Нийгэмд түгээмэл байгаа хэвшмэл ойлголт нь хүмүүсийн зан үйл буюу хэрхэн бодох, биеэ яаж авч явах, ямар сонголт хийх, ямар шийдвэр гаргахад нөлөөлдөг. Ингэснээр хүмүүс хоорондын харилцаанд нөлөөлж, хүмүүсийг баригдмал загварт оруулдаг. Мөн эрх мэдлийн, хөрөнгө

нөөцийн, нийгэмд эзлэх байр суурийн ялгавартай байдлыг үүсгэх хөрс суурь нь болдог.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, тодорхой бүлгийн хүмүүсийг нийгэмд уламжлагдан тогтсон хандлага, хүлээлтэд нийцүүлэн зан үйл, биеэ авч явах байдлыг багаас нь зааж хэвшүүлдэг ба "эрэгтэйлэг", "эмэгтэйлэг" шинж байдлын талаарх итгэл үнэмшлийг суулгадаг. Тухайлбал, эрэгтэйчүүд олон таван үггүй, уйлдаггүй, гэр бүлээ тэжээгч, харин эмэгтэйчүүдийг уян хатан, дуулгавартай, асран халамжлагч гэж үзэх үнэлэмж, нийгмийн хүлээлт давамгайлж, энэ нь хүмүүсийн харилцаанд нөлөөлдөг.

Жендэрийн үүрэг

Эрэгтэй, эмэгтэй хүний аль алинд ногдуулдаг үүрэг хариуцлага, хязгаарлалт юм. Энэ нь нийгмийн нөөц бололцооноос хүртэх боломж, ялгаатай байр суурийг тодорхойлдог. Жендэрийн үүрэг нь тухайн нийгэм, соёлд эрэгтэй, эмэгтэй хүнийг юу хийх, ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхойлсон ойлголт. Энэ нь 1) эрэгтэй, эмэгтэй хүний нийгэмд эзэлдэг буюу эзлэх ёстой байр суурь, 2) тэдний дагаж мөрдвөл зохих зан үйл, хийх үйлдлийн тухай дүрэм журам, 3) эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэдэг үүргийг илэрхийлсэн 3 талт ойлголт юм.

Жендэрийн үүрэг нь хүйсийн онцлогоосоо үүдэн амьдралын тодорхой үе шатанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг ялгаатай ажил, үүрэг төдийгүй "эмэгтэйлэг" "эрэгтэйлэг" байхын талаар тухайн нийгэм, соёлд хэрхэн авч үздэгээс үүдэн эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгмийн зүгээс оноож буй "зохиомол" үүрэг юм. Эдгээр нь хамтдаа тэдний гадаад дүр төрх, зан авир, нийгэмд эзлэх байр суурийг хэм хэмжээ болгон тодорхойлдог].⁴

Жендэрийн үүрэг нь тухайн нийгэм, олон нийт, нийгмийн бүлэг дотор эмэгтэй эрэгтэй, тодорхой бүлгийн хүмүүсийн хувьд зөв зохистой хэмээн тооцогддог дүр төрх, үнэлэмж, байр суурийн талаар харилцан адилгүй хүлээлт үүсгэж, тодорхой дүр (эмэгтэйлэг болон эрэгтэйлэг байдал), үнэлэмжийг тулгадаг. Жендэрийн үүрэгт нас, анги давхраа, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёл, технологийн орчин нөлөөлдөг.

Тэдгээр дүр төрх, үнэлэмж, үүрэг, хариуцлага, байр суурь, хүлээлт нь олон хүчин зүйлээс шалтгаалан хувьсан өөрчлөгддөг ба нийгэм, соёл бүрт харилцан адилгүй. Хүүхэд хөхүүлэх зэрэг зарим үүрэг хариуцлага нь биологийн хувьд тодорхойлогдсон учраас өөрчлөгдөх боломжгүй. Гэвч асран халамжлах зэрэг зарим үүрэг хариуцлага нь нийгмээс зохиогдсон учир өөрчлөгдөж болно.

4 Жендэр ба бодлого төлөвлөлт, Жендэрийн үндэсний хороо, Ж.Занаа, О.Оюунцэцэг, Б.Онон, Т.Амгалан, 2018 он.

Жендэрийн үүргийг 3 төрөлд ангилдаг:

1. Үйлдвэрлэлийн үүрэг: Энэ нь бүтээгдэхүүн боловсруулах, бараа үйлчилгээ үйлдвэрлэх зэргээр орлого олох үйл ажиллагаа ба хөлстэй хөдөлмөрт тооцогдоно.

2. Нөхөн үйлдвэрлэлийн үүрэг: Энэ нь хүүхэд тээж төрүүлэх, асрах болон хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд анхаарал, халамж тавих, өрхийн гишүүдээ асран халамжлах, ахмад настан, өвчтэй хүний асаргаа, ус авах, хоол унд бэлтгэх зэрэг үйл ажиллагаа ба голдуу хөлсгүй хөдөлмөрт тооцогддог.

3. Олон нийтийн үүрэг: Тухайн хамт олон, бүлэгт байгаа хүмүүсийн төлөө гүйцэтгэх үүрэг юм. Голдуу үнэлгээгүй, хийгээд л байдаг хэрнээ шагнал, урамшуулал авдаггүй ажил байдаг.

Эмэгтэй эрэгтэй хүний хэн хэн нь нийгэмдээ үйлдвэрлэлийн, нөхөн үйлдвэрлэлийн болон олон нийтийн менежментийн үүргүүдийг гүйцэтгэдэг боловч өрх гэрээ тэжээгч хэмээн тооцогддог эрэгтэйчүүд үйлдвэрлэлийн үүргээ гүйцэтгэхэд цагаа илүү зарцуулах боломжтойгоос гадна үүгээрээ тэд нэгэн дор олон талын үүргээ биелүүлж чаддаг. Харин эмэгтэйчүүдийг хоёрдогч цалин хөлс ологч гэж үзэх нь түгээмэл бөгөөд тэд олон ажлыг амжуулан хийж, хязгаарлагдмал хугацаанд бүгдийг тэнцвэртэй гүйцэтгэх хэрэгтэй болдог. Тиймээс ажлын цагаа зохицуулах болон уян хатан байлгах нь эмэгтэйчүүдэд илүү чухал бөгөөд тэд энэ хүрээнд илүү их асуудалтай тулгардаг. Эмэгтэй эрэгтэй хүмүүс эрт дээр үеэс нийгэмд ялгаатай үүрэг гүйцэтгэж ирсэн учраас тэдэнд тулгарах соёл, институцийн, биет болон эдийн засгийн саад бэрхшээл харилцан адилгүй бөгөөд олонхи нь тогтолцооны ялгаварлал, өрөөсгөл хандлагаас эхтэй байдаг.⁵

Жендэрийн үүрэг, түүнээс үүдсэн жендэрийн харилцаа нь хөрөнгө нөөц, эд баялагийг хэн хүртэж, өмчилж, захиран зарцуулж, хянахыг тодорхойлдог ба эрх мэдэл, гэр бүл, нийгэмд эзлэх байр суурийн ялгаатай байдлыг үүсгэх хөрс суурь нь болдог.

Алхам 2. Жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт

Жендэрийн тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралдаа эн тэгш үнэлэгдэж, хөгжлийн явцад оролцох, үр шимийг хүртэх тэгш боломжоор хангагдаж, хүйсийн ялгаваргүйгээр эдгээрийг эдлэх бололцоо, хүртэх боломж нь тэгш байх асуудал юм.

Монгол Улсын “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн 4.1.2-д “Жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш

⁵ Жендэрийн аудитын чиглүүлэгчдэд зориулсан гарын авлага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжлийн замнал сан, 2017 он.

эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ гэж тодорхойлсон.

Жендэрийн тэгш байдал нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн гүйцэтгэх үүрэг, нийгэмд эзлэх байр суурь болон нөөц боломж нь ямар хүйстэй болж төрснөөс шалтгаалахгүй гэсэн утгыг илэрхийлдэг. Гэхдээ энэ нь эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд адилхан, эсвэл ялгаагүй болох ёстой гэсэн үг биш. Тэдний зан үйл, тусгай буюу өвөрмөц хэрэгцээ, сонирхол болон нөхцөл байдал нь өөр учраас тэдэнд адил боломж олгох, шударга хандах, ялгаварлалгүй байхын тулд ялгаатай хэрэгцээг нь ойлгож, жендэрийн мэдрэмжтэй хандах нь нэн чухал.

Жендэрийн ялгаварлан гадуурхалт- улс төр, эрх зүй, эзийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ. Жендэрийн ялгаварлан гадуурхалт нь 3 хэлбэрээр илэрдэг. Үүнд:

1. Шууд ялгаварлан гадуурхалт
2. Шууд бус ялгаварлан гадуурхалт
3. Тогтолцооны ялгаварлан гадуурхалт

Шууд ялгаварлан гадуурхалт нь хүйсээр ялгаварлаж, адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон, хамааралт байдалд оруулсан буюу оруулахыг завдсан үйлдлээр илэрдэг. Нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас нь шалтгаалан залуу эмэгтэйчүүдийг ажилд авахаас татгалзах нь шууд ялгаварлан гадуурхалтын нэг жишээ юм.

Шууд бус ялгаварлан гадуурхалт нь нэг хүйсэд хамаарахгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг хэлнэ. Мөн хүйсийн шинжтэй аливаа зааг, ялгаа агуулаагүй мөртлөө адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс нь дорой байдалд ороход хүргэдэг байдлыг хэлнэ. Жишээлбэл, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн амьдралын хэв маяг өөр өөр байдлаас хамаарч ихэнхдээ эрэгтэйчүүд байгууллагадаа тогтвортой ажилладаг бол эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэхдээ орж, гарч хөдөлгөөнтэй ажилладаг. Гэр бүлийн үүрэг хариуцлагыг анхаарч тооцдоггүй цагийн хуваарь нь шууд бус ялгаварлалын шинжийг агуулдаг.⁶

6 Жендэр ба бодлого төлөвлөлт, Жендэрийн үндэсний хороо, Ж.Занаа, О.Оюунцэцэг, Б.Онон, Т.Амгалан, 2018 он.

Тогтолцооны ялгаварлан гадуурхалт гэж хүлээн зөвшөөрөгдөхүйц мэт ойлгогдох хэрнээ тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэхэд хүргэсэн хандлага, журам, хууль тогтоомжийн улмаас хүн амын аль нэг хэсгийн эрх ашгийг хөндөж, үр дагавар нь тодорхой хугацаанд үргэлжилсэн байдлаар илэрдэг үгүйсгэл, хязгаарлалт, ялгаварлалыг хэлнэ. 1990-ээд оны эхээр олон хүүхэдтэй эхчүүдийг эрт тэтгэвэрт гаргасны улмаас эмэгтэйчүүд 35 настайдаа хүртэл тэтгэвэрт гарч, өнөөг хүртэл хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч олон жил хохирч байгаа нь тогтолцооны ялгаварлан гадуурхлын тод жишээ юм.

СЭДЭВ 3. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Зорилго: Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрлүүд, суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийн талаар нэгдсэн ойлголт өгөх

Үндсэн ойлголт:

- ✓ Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэл

Олгох мэдлэг, ур чадвар:

- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн мөн чанарыг тодорхойлох
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний ялгааг мэдэх
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой нийгэмд тогтсон ташаа мэдээлэл, ойлголтыг илрүүлэх
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийг ялган ойлгох
- ✓ Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн онцлогийг танин мэдэх

Хүрэх үр дүн:

- ✓ Жендэр ба хүчирхийллийн харилцан хамаарлыг ойлгосноор хохирогчийг ойлгох, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломжийг тодорхойлдог болно.

Хичээлийн агуулга:

- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай ойлголт
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх төөрөгдөл ба бодит байдал
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийллийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс

Гол санаа:

- ✓ “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” гэж жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдэд бие махбодийн, бэлгийн болон сэтгэлзүйн дарамт учруулахыг завдах эсвэл ийм үйлдлийг хэлнэ. Үүнд хувийн болон олон нийтийн газарт ийм үйлдэл хийхээр заналхийлэх, хүний эрх чөлөг хязгаарлах хүч хэрэглсэн эсвэл шаардсан үйлдлийг багтаана.
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэл нь бусдыг хянах, хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх, зовиур шаналал, хор хохирол учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэл юм.
- ✓ Жендэрийн тэгш бус байдал, жендэрийн тэгш бус харилцааг тогтоож бэхжүүлэх, үргэлжлүүлэхэд ашигладаг аливаа хэлбэрийн хүчирхийллийг жендэрт суурилсан хүчирхийлэлд тооцдог.
- ✓ Эрх мэдлийн тэгш бус харилцаа нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан болдог.

- ✓ Архидалт, ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин зэрэг нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлс мөн.
- ✓ Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч өртөж болох ба ихэвчлэн охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж, гэр бүл хамт олон, нийгэмд далд нуугдмал байдлаар оршиж байдаг.
- ✓ Хүчирхийллийн төрөл
 - Бие махбодын хүчирхийлэл
 - Бэлгийн хүчирхийлэл
 - Эдийн засгийн хүчирхийлэл
 - Сэтгэл санааны хүчирхийлэл

Манай улсад жендэрт суурилсан хүчирхийллийн дараах төрлүүд түгээмэл байдаг.

- Гэр бүлийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Хүн худалдаалах гэмт хэрэг
- Бэлгийн дарамт

Хичээлийн явц:

Хэрэглэгдэх оролцооны аргууд:

- Бүлгээр ажиллах
- Тодорхойлолт бүтээх
- Хэлэлцүүлэг

Уг сэдэв нь 2 алхамд хуваагдана.

Алхам 1: Бүлгийн ажил: Оролцогчид бүлгээр хуваагдана. Үүнд: нэг бүлэг 5 гишүүнтэй байна. Бүлэг бүр жендэрт суурилсан хүчирхийллийн нийгэмд тогтсон сөрөг хандлагатай хэлц үг аман яриа, болон шог үг хэллэгүүдийг бүлгээрээ ярилцан цаасан дээр буулгана. Буулгасан санаагаа бусад бүлгүүдэд танилцуулна.

Алхам 2: Бүлгийн ажлын дараа оролцогчид эдгээр үг хэллэгүүд нь гэр бүлийн харилцаа болон нийгэмд хэрхэн сөргөөр нөлөөлдөг талаар богино хэмжээний хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Дараах дүгнэлтэнд хүрэхэд нь чиглүүлнэ.

- Эдгээр үг хэллэг сөрөг хандлагууд нь жендэрт суурилсан хүчирхийллийг өдөөж гаргах нэг шалтгаан болж байна.

- Мөн гэр бүлд эрх мэдлийн тэнцвэргүй харилцааг бий болгож гэр бүлийн хэн нэг гишүүн гэр бүлдээ илүү их эрх мэдэлтэй болоход дэмжлэг болж байна.
- Эдгээр хүчин зүйл нь нийгэмд жендэрт суурилсан хүчирхийлэл гарахад өдөөгч хүчин зүйл болж байна гэдгийг ойлгуулахад анхаарна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл

“Жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

Жендэрт суурилсан хүчирхийлэл \ЖСХ\ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд хүйсээс нь шалтгаалан нийгмээс оноосон, хуваарилсан үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурийн талаарх хүлээлт, шахалтад үндэслэн үйлдэгддэг. Хянах, эрх мэдлээ мэдрэхийн тулд хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, хянах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх зэрэг ямар ч аргаар үйлдэгдэж болох ба зовиур шаналал, хор хохирол учруулах буюу учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэл юм.

ЖСХ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба бусад төрлийн хүчирхийлэлтэй холбоотой (эрэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй гэх мэт).

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж “жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдэд бие махбодын, бэлгийн болон сэтгэлзүйн дарамт учруулсан болон учруулахыг завдах үйлдлийг хэлнэ. Үүнд: хувийн болон олон нийтийн орчинд ийм үйлдэл хийхээр заналхийлэх, хүний эрх чөлөөг хязгаарлах хүч хэрэглэсэн эсвэл шаардсан үйлдлийг багтаана”⁷

ЖСХ нь хувийн харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, сургуулийн орчинд, гудамж талбай зэрэг нийгмийн бүхий л хүрээнд, үйлдэгдэж, нийгмийн бүх анги, давхаргын дунд тохиолддог.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч өртөж болох ч ихэвчлэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж, гэр бүл, хамт олон, нийгэмд далд, нуугдмал байдлаар оршин байна.

Жендэрийн тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш бус харилцааг тогтоох, бэхжүүлэх, хадгалахад ашигладаг аливаа хэлбэрийн хүчирхийллийг жендэрт суурилсан хүчирхийлэлд тооцдог.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд нийгмээс оноосон үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь, хүлээлтийг тодорхойлж, тэдний хувьд “зөв”, “зүйтэй” хэмээн тооцогдох зан үйл, юу хийж болох, болохгүйг тулгаж,

7 НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал. Нэгдүгээр бүлэг.

хүлээлт, шахалт үүсгэн үйлдэгддэг учраас жендэрт суурилсан хүчирхийлэл гэж нэрлэгддэг. Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалд үндэслэгдсэн байдаг ба суурь шалтгаан нь жендэрээс үүдэлтэй эрх мэдлийн тэнцвэргүй байдал юм.

ЖСХ нь хувийн, ойр дотны харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, боловсролын орчинд, гудамж талбайд, ер нь нийгмийн бүхий л хүрээнд үйлдэгддэг. Эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа суурь шалтгаан нь учраас ихэвчлэн эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэгддэг. Нийгэмд хэвийн үзэгдэл болтлоо хүлээн зөвшөөрөгдөж, нийгэмд тогтсон хэм хэмжээ, хүмүүсийн үзэл хандлагаар дэмжигдэж байдаг.

ЖСХ-д олон хүчин зүйл нөлөөлдөг, тэдгээр хүчин зүйлс нь давхцдаг, өөр, өөр нөхцөлд янз бүрээр илэрдэг, олон талт асуудал юм. Энэ нь амьдралын турш тохиолдож болох ба амьдралын аль мөчлөгт тохиолдож болохоос шалтгаалан өөр өөр байдаг ч хоорондоо холбоотой.

Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд

Манай улсад жендэрт суурилсан хүчирхийллийн дараах төрлүүд түгээмэл үйлдэгдэж байна:

- Гэр бүлийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл (гудамж, талбайд үйлдэгдэх хүчин, болзооны хүчин, ураг төрлийн хүчин, гэрлэгсдийн хүчин, бэлгийн халдлага зэрэг)
- Хүн худалдаалах
- Бэлгийн дарамт (энэ нь боловсролын орчинд, бас ажлын байранд голчлон үйлдэгддэг)

Хүчирхийллийн төрлүүд, түүний илрэх үйлдүүдийг мэдсэнээр хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхээс гадна бусдад хугацаа алдахгүй тусламж, дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ.

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх төөрөгдөл ба бодит байдал

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх өрөөсгөл ойлголт олон байдгаас олон нийт төдийгүй хохирогчид хүртэл төөрөлддөг. Энэ нь жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой байдаг. Эдгээрээс зарим өрөөсгөл ойлголтыг тодруулж тайлбарлавал:

Төөрөгдөл 1: "Манай уламжлалын нэг хэсэг" гэж үзэх

Бодит байдал: Уламжлалыг хэрхэн ойлгодгоо бид эргэн харах шаардлагатай. Уламжлал нь тухайн улс орон, нийгмийн хувьд олон жилийн туршид шүүн тунгаагдсан, дараа үедээ өвлүүлэн үлдээх үнэт зүйл байдаг.

Харин хүчирхийлэл нь хүнд айдас, түгшүүр төрүүлж, зовоон шаналгадаг. Хэн нэгнийг ялгаварлаж, зовиур, шаналал авчрах нь манай уламжлал яавч биш.

Төөрөгдөл 2. Хүчирхийлэл нь санамсаргүй үйлдэл

Бодит байдал: Хүчирхийлэл хэзээ ч санамсаргүй байдаггүй. Эрх мэдлийн давамгайл байдлаа ашиглан, хяналтаа тогтоож, хохирогчийг хамааралд, дуулгавартай байдалд оруулах зорилгоор үйлдэгддэг, шууд санаатай үйлдэл, эс үйлдэл юм.

Төөрөгдөл 3. Хохирогчоос өөрөөс нь болсон гэж буруутгах

Бодит байдал: Хүчирхийлэлд ямар ч зөвтгөл, хүлээн зөвшөөрөгдөх түвшин байх учиргүй. Үзэл бодлоо илэрхийлэх, санал нийлэхгүй байх нь хүчирхийлэлд өртөх шалтгаан биш. Буруутай байлаа ч хүчирхийлэл, дарамт үйлдэх аргаар зөрчил, асуудлыг шийдвэрлэж болохгүй.

Төөрөгдөл 4. Эрчүүд ч гэсэн хүчирхийлэлд өртдөг байтал эмэгтэйчүүдийг түлхүү ярих юм.

Бодит байдал: Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч, амьдралынхаа аль ч хугацаанд, хаана ч өртөж болно. Гэмт хэрэг, зөрчлийн статистикаас харахад дийлэнх нь охид, эмэгтэйчүүд хохирч байна.

Төөрөгдөл 5. Эрчүүд төрөлхөөсөө л түрэмгий зан ааштай.

Бодит байдал: Бүх эрчүүд хүчирхийлэл үйлдэгч биш. Хүчирхийлэл нь сонголт, сурсан зан үйл юм.

Төөрөгдөл 6. Хүчингийн хэргийн хохирогч нь зөвхөн эмэгтэйчүүд л байдаг.

Бодит байдал: Цөөн тохиолдолд хөвгүүд, эрэгтэй хүн ч ялгаагүй хүчингийн хэргийн хохирогч болдог.

Төөрөгдөл 7. Хүчиндэгч нь танихгүй хүмүүс байдаг.

Бодит байдал: Харамсалтай нь ихэнх тохиолдолд хүчиндэгч нь хохирогчийн сайн таньдаг хүн, хөрш, хамаатан садан, дотны хүн нь байдаг. Тэр ч байтугай найз залуу, төрсөн болон хойд эцэг байх тохиолдлууд гардаг.

Төөрөгдөл 8. Нэг ажлын газрын хүмүүсийн хооронд тоглоом, наргиа байж л байдаг. Энэ үедээ биед нь хүрч, тэвэрч болно шүү дээ.

Бодит байдал: Хүсээгүй үед бэлгийн сэдэлтэй санал тавих, биед хүрэх нь бэлгийн дарамт болно.

Төөрөгдөл 9. Зөвхөн гадаадад худалдаалагдсан хүн л хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болно.

Бодит байдал: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь зөвхөн гадаадад худалдаагддаггүй. Биеийг нь үнэлүүлж, ашиг олох зорилгоор хил дамжуулахгүйгээр дотооддоо хүнийг худалддаг зохион байгуулалттай бүлгүүд байдаг.

Жендэрт суурилсан хүчирхийллийн шалтгаан, эрх мэдэл, хүчирхийллийн уялдаа

Хүчирхийлэл нь эрх мэдэлтэй холбоотой жендэржсэн үзэгдэл юм. Хүчирхийллийг зогсооё гэвэл түүнийг үүсгэж байгаа үндэс шалтгаантай нь ажиллах шаардлагатай.

Хүчирхийллийн илрэл болон үр дагаврууд нүдэнд илт харагддаг учраас эдгээрийг хүчирхийллийн суурь шалтгаанд тооцож, төөрөгдөл үүсгэдэг.

Бид ихэвчлэн хүчирхийллийн хэлбэрүүд болон үр дагаврын талаар л ярилцдаг. Харин "яагаад хүчирхийлэл үйлдэгдээд байна" гэж бараг асуудаггүй.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн харилцаанд эрх мэдлийн тэнцвэргүй байдал оршиж, түүнээс шалтгаалан хүчирхийлэл үйлдэгдэж байдаг. **Эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан юм.** Эрх мэдлийн тэгш бус байдал нь зөрчил, айдас, түгшүүр, хонзогнол, түрэмгийлэл, хүчирхийллийг төрүүлж байдаг. Хүчирхийлэл нь эрх мэдлээ сөргөөр ашиглаж, бусдыг хянаж, дарамтлан, хамааралд оруулж байгаатай холбоотой. Эрх мэдэл хүн бүрт байдаг ч бусдыг хянаж, дарамтлахад ашиглаж, хүчирхийлэл үйлдэж байгаа нь эрх мэдлийн сөрөг хэрэглээ юм.

Эрх мэдэл бидний амьдралын салшгүй нэг хэсэг. Эрх мэдэл нь бидний шийдвэр, сонголтонд байнга нөлөөлж байдаг ч бид эрх мэдлийн тухай бараг боддоггүй. Эрх мэдэл нь өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байх, шийдвэрээ өөрөө гаргах, сонголт хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, амьдралаа өөрийнхөөрөө бүтээх хүч, чадамж юм. Эрх мэдлийн доорх 4 төрөл бий.

1. Дотоод хүч, эрх мэдэл
2. Хамтын хүч, эрх мэдэл
3. Өөрчлөлт хийх, үйл хэрэг болгох эрх мэдэл
4. Бусдыг хянах, дарамтлах эрх мэдэл

Дотоод хүч, эрх мэдэл: Амьдралдаа болон эргэн тойрондоо эерэгээр нөлөөлөх чадвартай гэдгээ ухаарахад бидний дотроос ундрэн гардаг хүч. Бид өөрт буй энэ эерэг эрх мэдлээ нээснээр эргэн тойронд, хамт олны дунд шударга бус байдалд хүргэж байгаа эрх мэдлийн сөрөг хэрэглээг зогсоох эрмэлзлэлтэй болдог.

Бусдыг хянах, дарамтлах эрх мэдэл: Хэн нэгэн хүн буюу бүлэг хүмүүс өөр хүнийг эсвэл өөр нэгэн бүлгийг хянах, эрхийг нь хязгаарлаж, дарамтлахад ашигладаг эрх мэдэл. Хэн нэгэн эрх мэдлээ бусдыг хянах, эрхийг нь хязгаарлах хэлбэрээр ашиглах нь хүчирхийлэл мөн. Эрх мэдлийн тэгш бус байдал нь айдас, түгшүүр, дарамт, хүчирхийллийг төрүүлж байдаг.

Хамтын хүч, эрх мэдэл: Ганц, ганцаараа хийж чадахгүй зүйлээ хоёр

буюу түүнээс дээш хүмүүс нийлж хийхэд мэдрэгддэг эрх мэдэл.

Үйл хэрэг болгох, өөрчлөлт хийх эрх мэдэл:Хувь хүмүүс, бүлгүүдийн эерэг өөрчлөлт авчрах чадамж буюу тэдний итгэл үнэмшил, эрч хүч, үйл ажиллагаа юм.

Хүн бүрт эрх мэдэл бий. Эрх мэдэл нь хязгаарлагдмал зүйл огт биш. Аль ч хүйсийн хүнд нөгөө хүйсийн хүнээс дээгүүр эрх мэдэл байхгүй. Хэн нэгэн эрх мэдэлтэй байхын тулд бусдаас эрх мэдлийг нь авах шаардлагагүй.

Хүмүүс эрх мэдлээ ихэнхдээ эерэгээр ашигладаг бол, харамсалтай нь зарим хүн сөргөөр хэрэглэдэг. Дотоод хүч чадлаа нээн, бусадтай хүчээ нэгтгэн, эргэн тойрноо өөрчлөх чадамжаа мэдэрч байгаа бол энэ нь эрх мэдлээ эерэгээр ашиглаж байгаагийн илрэл юм. Харин бусдыг үл хүндэтгэж, эрх чөлөөг нь хянаж байгаа бол энэ нь эрх мэдлээ сөргөөр ашиглаж байгаагийн илрэл юм.

Эрх мэдлийн сөрөг хэрэглээ нь эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг үүсгэдэг ингэснээр дарамт, хүчирхийллийг төрүүлж байдаг.Бид зарим нөхцөл, тохиолдолд өөрсдийгөө эрх мэдэлтэй гэж мэдэрдэг, харин зарим үед эрх мэдэлгүй, хүчин мөхөс байна гэж мэдэрдэг. Эдгээр нөхцөл, тохиолдол нь хүн бүрийн хувьд ялгаатай.

Бид ихэвчлэн хүчирхийллийн үр дагавар болох бэртэл, гэмтэл, сэтгэл санааны цочрол, хямрал, эрүүл мэндийн хохирлын талаар л ярилцдаг. Харин "Яагаад энэ хүчирхийлэл үйлдэгдээд байна?" гэж бараг асуудаггүй.

Эрх мэдлээ бусдыг хянах, дарамтлах байдлаар сөргөөр ашигласны улмаас үүссэн эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан юм. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү эрх мэдэлтэй байх ёстой гэсэн хүлээлт манай нийгэм, хамт олны дунд давамгайл байдаг тул заримдаа бид дотно харилцаандаа эрх мэдлийн тэгш бус байдалд байгаагаа өөрсдөө ч ухаараагүй байдаг. Зарим хүн эрх мэдлийн тэнцвэргүй байдал байгааг ойлгож байдаг боловч үүнд дасал болсон байдаг учраас өөрчлөхийг оролддоггүй.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийг хүсч байгаа бол эрх мэдлээ сөргөөр ашиглахыг зөвшөөрөөд байгаа хэм хэмжээг өөрчлөхөд анхаарах шаардлагатай.

Хүмүүс эрх мэдлээ сөргөөр ашиглахаас татгалзсан үед хүчирхийллээс ангид амьдарч чадна. Хамт олон, олон нийт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг эсэргүүцэж тэгш бус байдлаас татгалзаж, дуу хоолойгоо нэгтгэх тохиолдолд л жендэрт суурилсан хүчирхийлэл эцэс болно.

Архидалт, ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин зэрэг нь

жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлс болно. Жишээ нь, архи уудаг хүн бүр хүчирхийлэл үйлдэхгүй байхад архи огт амсдаггүй атлаа хүчирхийлэл үйлддэг хүн байдаг. Энэ нь дээрх хүчин зүйлс нь суурь шалтгаан биш болохыг харуулж байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, стратеги

ДЭМБ, Александр Бутчарт болон Америкийн Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн төв, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох олон улсын түншлэлийн байгууллага, Охидтой хамтдаа байгууллага, Дэлхийн банк, Пан Америкийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, PEPFAR байгууллага зэрэг олон улсын 10 гаруй байгууллага хамтран хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, зарчмыг 2016 онд тодорхойлж, улс орнууд хэрэгжүүлж эхлээд байна.

Хүчирхийллийг эцэс болгоход зөвхөн хууль батлах, хэрэгжүүлэхээс гадна нийгмээрээ маш олон салбар байгууллага, эцэг эх, гэр бүлийн оролцоотой хамтын хүчээр тэмцэх шаардлагатай. Хүчирхийлэл, ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын тулд дараах 7 стратеги (**INSPIRE**)-ийг хэрэгжүүлэхийг дээрх байгууллагууд зөвлөсөн:

1. (I) Холбогдох хуулийн хэрэгжилтийг сахиулах
2. (N) Нийгмийн зөв хэм хэмжээ, үнэт зүйлс бий болгох
3. (S) Аюулгүй орчин бүрдүүлэх
4. (P) Эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэгийг бий болгох
5. (I) Хүн ам, гэр бүлийн орлого болон эдийн засгийг сайжруулах
6. (R) Хариу арга хэмжээ, бэлэн байдал, дэмжин туслах үйлчилгээнүүдийг сайжруулах
7. (E) Хүн амын мэдлэг, боловсрол, амьдрах чадваруудыг сайжруулах

INSPIRE – гэдэг нь Засгийн газраас эхлээд жирийн иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшил гээд хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх чиглэлээр ажилладаг бүх байгууллага, хүн бүрт зориулсан нотолгоонд суурилсан хэрэглэгдэхүүн юм. Хүчирхийллийг бууруулах хамгийн өндөр боломж бүхий урьдчилан сэргийлэх хөтөлбөр бөгөөд энэхүү 7 стратеги нь хоорондоо нягт уялдаатай, нэг салбар дангаар хэрэгжүүлэхэд үр дүн бага гардаг учир салбар дундын хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх нь хамгийн чухал юм. Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд нийгмийн бүхий л салбар, ялангуяа гол гол салбар, агентлагууд, хамтрагч бусад байгууллага, мэргэжилтнүүдийн

хамтын оролцоо, дэмжлэг туйлын чухал болохыг онцлон тэмдэглэжээ.

Хуулийн хэрэгжилтийг сахиулах – Хүчирхийлэлд нөлөөлөх зан үйлээс урьдчилан сэргийлэх, архины хэт хэрэглээг багасгах, галт зэвсэг, бусад зэвсгийг хүүхэд залуучуудад хүртээмжтэй байгаа байдлыг хязгаарлахад чиглэсэн хуулийн хэрэгжилтийг сахиулах, үүний тулд эцэг, эх, багш, асран хамгаалагчдын зүгээс “Хүүхдийг хэрцгийгээр шийтгэхийг хориглосон”, “Бэлгийн хүчирхийлэл болон хүүхдийн мөлжлөгийг хориглосон”, “Архины зохисгүй хэрэглээнээс сэргийлсэн хууль”, өсвөр насны хүүхдэд галт зэвсэг, бусад зэвсгийн олдоцыг хязгаарласан зэрэг хууль тогтоомжуудийг батлан хэрэгжүүлэх шаардлагатай.

Нийгмийн зөв хэм хэмжээ, үнэт зүйлс – хүүхэд, өсвөр үеийнхэн эмэгтэйчүүдэд зориулсан хүчирхийллийн бус, тэднийг хүндэтгэсэн, хөгжих боломжийг нь хангасан, жендэрийн эерэг, тэгш харилцааг дэмжсэн хэм хэмжээ, үнэт зүйлсийг нийгэмд бий болгох, бэхжүүлэх, хязгаарласан болон хор уршигтай жендэрийн болон нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх байдлыг өөрчлөх, олон нийтийг идэвхжүүлэх, хөндлөнгийн интервенц явуулах зэрэг асуудлууд орно.

Аюулгүй орчин – аюулгүй гудамж болон хүүхэд залуучуудын цуглаж цагаа өнгөрөөх бусад орчинг бүрдүүлж, аюулгүй байдлыг тогтвортой хангах, халуун цэгүүдийг шийдвэрлэх замаар хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийн тархалтыг сааруулах, барилгажсан орчныг сайжруулах.

Эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэг – хүүхдийг хатуу гараар хүмүүжүүлэх явдлыг бууруулж, эцэг эх ба хүүхдийн хооронд эерэг харилцааг бий болгох, гэрээр айлчлах хөтөлбөр, эцэг, эхийн сургалт, дэмжлэгийг хөтөлбөрийн нэг хэсэг болгох, орон нутагт бүлгээр дэмжлэг үзүүлэх үйлчилгээ бий болгох.

Хүн ам, гэр бүлийн орлого болон эдийн засаг – гэр бүлийн эдийн засгийн аюулгүй байдлыг сайжруулах, хүүхэдтэй зүй бусаар харилцах болон гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, бэлэн мөнгөний тусламж, хадгаламж, зээлийн хоршоо болон бичил санхүүг жендэрийн хэм хэмжээ, тэгш байдлын сургалттай хослуулан хэрэгжүүлэх.

Хариу арга хэмжээ, бэлэн байдал, дэмжин туслах үйлчилгээ – хүчирхийллийн урт хугацааны хор уршгийг багасгахын тулд хүчирхийллийн талаар мэдээлэх болон эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль эрхзүйн чанартай тусламж, үйлчилгээг хэрэгцээтэй бүх хүүхэд, эмэгтэйчүүдэд хүртээмжтэй болгон сайжруулах, зөвлөгөө өгөх, сэтгэл заслын аргууд, илрүүлэлтийг интервенцитай хослуулах, насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд зориулсан засан хүмүүжүүлэх хөтөлбөр, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулсан асралт гэр бүлийн үйлчилгээ бий болгох

Хүн амын мэдлэг, боловсрол, амьдрах чадвар– хүүхдэд үр өгөөжтэй, жендэрийн тэгш байдлыг хангасан боловсрол, нийгэм-сэтгэл хөдлөлийн талаар суралцах боломж, амьдрах ур чадварын сургалтыг илүү хүртээмжтэй болгох, аюулгүй бөгөөд хүүхдийг дэмжсэн сургуулийн орчин бүрдүүлэх, аюулгүй, дэмжигч сургуулийн орчин бүрдүүлэх, өөрсдийгөө хэрхэн бэлгийн хүчирхийллээс хамгаалах мэдлэгийг хүүхдэд төлөвшүүлэх, амьдрах ур чадвар болон нийгмийн чадварын сургалтууд, өсвөр насныхны дунд ойр дотны хамтрагчийн хүчирхийллээс хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх.

Энэхүү стратегийн үр дүнд хүрэх хамгийн чухал үйл ажиллагаа нь:

- 1. Салбар дундын үйл ажиллагаа, уялдаа холбоо**- орон нутаг түшиглэсэн хүүхэд хамгааллын тогтолцоо, үндэсний хэмжээнд хэрэгжих механизмууд, олон улсын механизмууд
- 2. Хяналт, шинжилгээ ба үнэлгээ** – хяналт, шинжилгээ, асуулгаар цуглуулах тоо баримт, захиргааны мэдээлэл, үнэлгээ юм.

Хэрэгжилтэд анхаарах асуудлууд:

- Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх амлалтууд байх
- Хэрэгцээг үнэлэх
- Урьдчилан сэргийлэхэд бэлэн байдлыг үнэлэх
- Интервенцийг сонгох, орон нутгийн онцлогт нийцүүлэх
- Үндэсний болон орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, бэлэн байдлыг хангах
- Өртөг зардлын тооцоо гаргах
- Санхүүгийн тогтвортой дэмжлэгийн эх үүсвэрийг тогтоох
- Хүний нөөцийг хөгжүүлэх, удирдах
- Хэрэгжилтийг хангах, хяналт, шинжилгээ, үнэлгээ тогтмол хийх

СЭДЭВ 4. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Зорилго: Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тогтолцооны талаар ойлголт өгөх

Үндсэн ойлголт:

- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл
- ✓ Хохирогч
- ✓ Даван туулагч
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн этгээд

Олгох мэдлэг, ур чадвар:

- ✓ Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн талаар нийгэмд тогтсон сөрөг хандлагыг ойлгох
- ✓ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах хууль эрхзүйн ойлголт, мэдлэгтэй болох
- ✓ Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн онцлогийг танин мэдэх
- ✓ Хохирогчийг хамгаалах асуудалд эрхзүйн орчинг оновчтой ашиглах ур чадварыг эзэмших

Хүрэх үр дүн:

- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрхзүйн орчинг мэдсэнээр хохирогчийг хамгаалах, хамтран ажиллах боломж нэмэгдэнэ.
- ✓ Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх чадавхи дээшилнэ.

Хичээлийн агуулга:

- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хэлбэр, илрэх шинжүүд
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагддаг, даамжирдаг, давтагддаг.
- ✓ Гэр бүлийн хүчирхийллийн бусад хүчирхийллээс ялгагдах онцлог
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах эрхзүйн зохицуулалтууд

Гол санаа:

- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл нь жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл үйлдэгдэж буй нэг төрөл юм.
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл нь эрх мэдлийн тэгш бус харилцаан дээр суурилан санаатай үйлдэгддэг.
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгддэг, давтагддаг, даамжирдаг. Хоорондын зай ойртох тутам амь насаа алдах эрсдэлд хүрдэг онцлогтой.
- ✓ Хохирогч нь хүчирхийллийн давтамж, даамжирлын үр дагавраас шалтгаалан хүчирхийллийн эргүүлэгт орсон байдаг.
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл нь сэтгэлзүйн болон эдийн засгийн харилцан хамаарал бүхий хүмүүсийн дунд үйлдэгддэг. Хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд амьдардаг.

- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зохицуулалт нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулиар хязгаарлагдахгүй, бусад хуулиудад бас туссан байдаг.
- ✓ Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиудаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг зохицуулсан.
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход зорилготой.

Хичээлийн явц:

Уг сэдэв нь 2 алхамтай. Хэрэглэгдэх арга нь лекц болон хэлэлцүүлэг байна.

Алхам 1: Гэр бүлийн хүчирхийллийн илрэх шинж тэмдэг, төрлүүд, хохирогч хамгааллын хууль эрхзүйн орчны талаар мэдээлэл өгөх

Алхам 2: Одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомж бодлогын бичиг баримт, хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж, асуулт хариулт байдлаар ойлголтыг бэхжүүлэх.

Алхам 1:

Гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэрээс ялгагдах онцлогийг харуулсан танилцуулга хийнэ. Гэр бүлийн хүчирхийлэл нь түүний давтамж, даамжралаас хамааран амь насанд эрсдэлтэй гэдгийг анхааруулж хэлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэл гэж Гэр бүлийн хүрээнд гэр бүлийн гишүүн, төрөл садан, гэр бүлээ бүртгүүлээгүй боловчхамтран амьдарч байгаа хүмүүс нь гэр бүлийн нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж, гэм хор учруулсан, эсвэл учрахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.1/

Гэр бүлийн хүрээнд хэн нэг нь нөгөөгөө хүч,эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулахзорилгоор хяналтаатогтоон,өөрийнхамаарал болон эрх мэдлийн тэнцвэргүй байдалд оруулж байгаа тэгш бус харилцаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл үйлдэгдэж байгаа нэг төрөл ба хүний амьд явах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, хараат бус байх эрхэд халдсан хүний эрхийн ноцтой зөрчил юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь нас, хүйс, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь, боловсрол зэргээс үл хамааран төрөл бүрийн хэлбэрээр үйлдэгддэг.

Гэр бүлийн хүчирхийллийг хүмүүс ихэвчлэн гэр бүл дотор эхнэр,

нөхрийн хооронд үйлдэгддэг гэж ойлгодог ч бодит байдалд өргөн хүрээг хамардаг. Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчтой нэг гэрт амьдардаг эсэхээс үл хамааран эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүнээс гадна хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа хүн, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа хүн болон тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү зэрэг ойр дотны харилцаатай хүмүүсийн хооронд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг.

Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй хүний хооронд үйлдэгдсэн хүчирхийлэл ялгаагүй гэр бүлийн хүчирхийлэлд тооцогдоно⁸.

Гэр бүлийн хүчирхийлэл хэзээ ч санамсаргүй үйлдэгдэхгүй. Биеэ барьж чадаагүй, хяналтаа алдсанаас шалтгаалж үйлдэгддэггүй. Эрх мэдэл, хяналтандаа хохирогчийг оруулах зорилго, сэдэл бүхий шууд, санаатай үйлдэл юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд

Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг хяналтандаа байлгахын тулд янз бүрийн арга, тактик ашигладаг. Үүнээс шалтгаалан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл гэсэн хэлбэртэй.

8 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйл, 2016 он.

“ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ОРОЛЦОО”

Бие махбодын хүчирхийлэл	Сэтгэл санааны хүчирхийлэл	Эдийн засгийн хүчирхийлэл	Бэлгийн хүчирхийлэл
<p>Гэр бүлийн гишүүний хэн нэг нь бусаддаа хяналтаа тогтоон, хамааралд оруулах зорилгоор биед нь халдан өвдөлт авчирч, бэртэл, гэмтэл учруулах болон учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ. Бие махбодын хүчирхийллийн үр дагавар нүдэнд шууд харагдахуйц байдаг тул хүчирхийллийн энэ төрлийг хүн бүр мэддэг. Гэхдээ энэ нь хамгийн их хэрэглэгддэг хүчирхийллийн төрөл биш юм.</p>	<p>Хэн нэг нь бусдынхаа хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, доромжлох, дорд үзэх, айлган сүрдүүлэх, заналхийлэх, нэр төр, алдар хүндийг нь гутаах, гүтгэх, мөрдөн мөшгих, ах дүү, төрөл төрөгсөд, хамт олноос нь тусгаарлах, бусадтай харилцахыг хязгаарлах, эд хөрөнгөө сүйтгэх, гэрийн тэжээмэл амьтанд уур хилэнгээ гаргах болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг хэлнэ. Энэ нь хамгийн түгээмэл үйлдэгддэг ч хүмүүс хүчирхийлэл гэж үзэх нь бага. Хохирогч ч бас ГБХ үйлдэгдэж байна гэж анзаарч таньдаггүй тул байнга давтагдаж байдаг. ГБХ-ийн бусад хэлбэрүүдтэй хавсардаг, нүдэнд илт харагдаж мэдрэгдэхгүй тул үр дагавар, хор уршгийг хэмжих, нотлоход төвөгтэй.</p>	<p>Гэр бүлийн гишүүн нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарлахыг хэлнэ. Санхүүгийн нөөцийг хяналтдаа байлгах зорилгоор цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсан аливаа үйлдэл, зан үйл хамаарна.</p>	<p>Гэр бүлийн гишүүн, сэтгэлзүйн болон ураг төрлийн хамааралтай хүний эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Бэлгийн сэдэлтэй үг хэллэг, онигоо ярих, зураг, кино, дүрс үзүүлэх, үнсэх, илж таалах зэргээр зөвшөөрөлгүй хүрэх, хүсээгүй байхад бэлгийн харьцаанд орохыг албадах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, зэвсэг, эсхүл өөр бусад зүйлсийг хэрэглэн бэлгийн шинжтэй үйлдэлд албадах, хүчиндэх болон хүчиндэхээр завдах үйлдлүүд орох ба үүгээр хязгаарлагдахгүй.</p>

Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар

Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар нь “далд үйлдэгддэг”, “давтагддаг”, “даамжирдаг”.

Далд үйлдэгддэг- Гэр бүлийн хүчирхийлэл нь хувь хүний болон гэр бүлийн нэр төртэй холбогддог эмзэг асуудал учир ихэнхдээ далд үйлдэгддэг. Далд үйлдэгддэг учраас ихэнхдээ гэрчгүй, гэр бүлийн бусад гишүүн нь асуудлыг ил гаргахыг хүсдэггүй. Ойр дотны хүмүүсээ байнга хүчирхийлдэг хүмүүс хохирогчийг хамааралдаа оруулсан байдаг тул хүчирхийллийг илчлэх, мэдээлэх гэсэн хүсэл, зоригийг нь хяналтаа ашиглан мохоодог тул эрт шатандаа илрэх нь ховор.

Давтагддаг- Зөрчил болон асуудлыг дарамт, хүчирхийллийн аргаар шийдэж сурсан зан үйлээ өөрчлөхийг хүчирхийлэл үйлдэгч хүсээгүй цагт гэр бүл дэх хүчирхийлэл байнга давтагдаж байдаг. Тиймээс хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдол болон үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг мэдээлэх, шуурхай таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн ээлжид анхаарах шаардлагатай.

Даамжирдаг- Гэр бүлийн хүчирхийлэл давтагдах тусмаа хоорондын зай нь ойртож, даамжирч байдаг. Давтамжийн хоорондын зай ойртох тусам амь насаа алдах эрсдэлд хүргэдэг тул хүчирхийлэлтэй харилцааны түүхийг судалж, хэн нь илүү давамгайлж, хэн нь илүү айдас, түгшүүртэй байгааг тодорхойлох шаардлагатай. Аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ тухайн гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааны түүхийг бүхэлд нь судална.

Гэр бүлийн хүчирхийлэл нь ураг төрөл, сэтгэлзүй болон санхүүгийн хамаарал бүхий хүмүүсийн дунд үйлдэгддэг. Энэ хамаарал нь заавал нэг гэр бүлд байгаа гишүүдийн хүрээгээр хязгаарлагдахгүй. Энэ онцлогийг харгалзан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг дараах 3 хүрээгээр тодорхойлсон.⁹ Үүнд:

1. Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа хүн;
2. Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү;
3. Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй хүн.

Хүчирхийлэл үйлдэгч зан үйлээ эргэн харж, хүчирхийлэл үйлдэхээ зогсоогоогүй цагт хүчирхийлэл давтан үйлдэгдсээр байдаг. Хохирогч дангаараа таслан зогсоох боломжгүй, тэд хүчирхийлэлтэй харилцааг зогсоох

9 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйл, 2016 он.

гарц хайж, даван туулахыг хичээдэг ч хүчирхийлэл давтагдах тусам итгэл, найдвар нь багасдаг учир хөндлөнгийн оролцоо зайлшгүй шаардлагатай.

Хүчирхийлэлтэй харилцааны тойрог

Гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгдэж, байнга давтагдан даамжирч байдаг харилцааны тойрог байдлаар явагддаг.

Энэ давтамж нь мөчлөг хэлбэрээр илрэхийг хүчирхийлэлтэй “харилцааны тойрог” гэж нэрлэдэг



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОЙРОГ



Зөрчил хуримтлагдах үе

- Маргаан, зөрчил ихсэж, хүчирхийлэл үйлдэгч бал сарын үед амлаж байсан амлалтаасаа бага багаар няцаж эхэлнэ.
- Хохирогчийн хийж буй үйлдэл бүрийг хянан, буруутгах шалтгааныг хайж, янз бүрийн шалтаг гарган хэрүүл өдөх, эсвэл дуугаа хураан элдэв дарамт шахалт үзүүлж эхэлнэ.
- Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг тайвшруулахын тулд юу ч хамаагүй хийх гэж оролдох ч энэ нь ихэнхдээ амжилтгүй болж дуусна.

Тэсрэлтийн үе

- Хүчирхийллийн тойргийн хамгийн аюултай үе шат юм.
- Эрх мэдэл, хяналтаа бүрэн тогтоохын тулд хүчирхийлэл үйлдэгчээс биеийн болон бэлгийн, эдийн засгийн дарамт, шахалт үзүүлэх нь маш хүчтэй болно.
- Хүчирхийлэл үйлдэгдэж, хэн нэгэн гэмтэж, бэртэж, амь насаа алдах эрсдэл өндөр.

Гэмшлийн үе

- Хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь "хяналтаа алдсан байсан" гэсэн шалтгаанаар уучлал хүсдэг. Зарим нь өөр бусад гадны хүчин зүйлсийг энэ бүхэнд буруутай гэж тайлбарлана
- "Өөрчлөгдөнө, дахин ийм үйлдэл хийхгүй" гэж амлана. Хохирогчид бэлэг авч өгөх, гэр орны ажлаа хийх зэргээр анхаарал тавихыг хичээнэ. Зарим нь эсрэгээр эвлэрэхгүй бол "ингэнэ, тэгнэ" гэх мэтээр айлган сүрдүүлнэ.
- Хохирогч халамж, амлалтад нь итгэж уучилдаг.

“Бал сар”-ын үе

- Гэр бүлийн гишүүн бүр сэтгэл хангалуун мэт боловч энэ бүхэн удаан үргэлжлэхгүй.
- Хүчирхийллийн эргүүлэг үргэлжилж, ямар нэг шалтгаанаар хүчирхийлэл үйлдэгч бухимдаж, айдас, түгшүүр эхэлнэ.

Хүчирхийлэлтэй харилцааны тойргийн үе шат бүрийг заавал дамждаггүй. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл өөрчлөгдөөгүй, тэдний харилцаан дахь эрх мэдлийн тэнцвэрт бус байдал хэвээр үед хүчирхийлэл зогсохгүй. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бал сарын шатыг алгасаж, зөрчил хуримтлагдах байдлаас шууд тэсрэлтийн үе шат руу шилжинэ.

Алхам 2: Хэлэлцүүлгийн асуулт

- Одоо хэрэгжиж байгаа хууль болон бусад бодлогын баримт бичигүүд хэр бодитой үр дүнтэй байна вэ?
- Хууль бодлогын бичиг баримтыг бодитойгоор хэрэгжүүлэхэд мэргэжилтнүүдийн зүгээс юу хийх шаардлагатай вэ? Оролцогчдын хэлсэн санаануудыг самбарын цаасан дээр буулгана.

Чиглүүлэгч дараах дүгнэлтийг хийнэ.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичиг
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дээд шүүхийн тайлбар
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр
- Нийгмийн халмжийн тухай хуулийн “Хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээ”
- Бусад хууль
- Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр гэх мэт байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тогтолцоо
- Хуулийн хэрэгжилтийг бодитой үр дүнтэй байлгахад мэргэжилтэн бүрийн оролцоо чухал бөгөөд төрийн анхан шатанд үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтнүүдийн хувьд иргэдэд хууль төрийн бодлогын үйлчилгээг үр дүнтэйгээр хангаж ажиллах нь ихээхэн ач холбогдолтой юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, цаг алдахгүй, шуурхай таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх болон урьдчилан сэргийлэх

тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн үндсийг тогтоосон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар:

1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, механизм
3. Хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын салбар дундын зохицуулалт
4. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, хугацааг нарийвчлан

тодорхойлсон.

Хуулийн үзэл баримтлал ба өмнөх хуулиас шинэчлэгдэн зарчмын өөрчлөлтүүд

1. Хуулийн зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлоход чиглэгдсэн байсныг өөрчилж, хохирогч, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтыг шинээр нэмсэн.
2. Хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөж, хамгаалалтын гадна үлдэж байсан хохирогчдыг энэ хуулийн зохицуулалтад хамааруулах боломжийг бүрдүүлсэн.
3. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас хамааралтай эмзэг байдлыг харгалзан хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг нэг бүлэг болгон шинээр оруулсан.
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа салангид, зарим яамны чиг үүрэг орхигдсон байгааг өөрчилж, байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, салбар дундын зохицуулалт, тэргүүлэн гүйцэтгэгч хэн байхыг тодорхой болгосон.
5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээсэн байгууллагуудын дунд мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн.
6. Гэр бүлийн хүчирхийллийг маргаан, иргэний хэрэг хэмээн үзэж, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг хохирогчийн үүрэг болгож, эрсдэлд оруулахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахад хүргэж байгааг өөрчилж, гэр бүлийн хүчирхийллийг зөрчил, гэмт хэрэгт тооцож, хариуцлага гарцаагүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.
7. Байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий тунхаглалын шинжтэй хуульчилсныг өөрчилж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах процедурыг тусгаж, холбогдох хуулиудын зохицуулалтыг нийцүүлэн өөрчилсөн.

8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зохицуулалт энэ хуулиас гадна Эрүүгийн эрх зүйн тогтолцооны бусад хуулийн зохицуулалтаар давхар хангагдах боломжийг бүрдүүлсэн. Жишээ нь: хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор цагдаагийн ажилтнаас эрх хэмжээгээ хэрэгжүүлэх үндэслэл, журам, хэргийн бодит байдлыг шалган тогтоохтой холбоотой зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хуулиар, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрлийг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар, шүүхээс оноосон ялыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиар гэх мэтчилэн цогц байдлаар тусгасан.
9. Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зохицуулалтыг цогц байдлаар хуульчилж, үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, тэдэнд үзүүлэх дэмжлэгийн хэлбэрүүдийг шинээр оруулсан.
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулаагүйгээс өрөөсгөл зохицуулалт үйлчилж байсныг халж, эрхзүйн цогц орчин бүрдүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд баримтлах зарчмууд:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхдээ дараах зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно. Үүнд:

1. Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх
2. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах
3. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг шуурхай хангах
4. Нууцлалыг хамгаалах
5. Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх
6. Хүчирхийллийг үл тэвчих.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тогтолцоо ба түүний оролцогч талууд

Гэр бүлийн хүчирхийлэл нь олон талт, төвөгтэй асуудал тул аюулгүй байдал, хууль, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагуудын нэгдмэл хүчин чармайлт, хамтын ажиллагаа, түншлэл зайлшгүй шаардлагатай. Нэг байгууллага, ганц мэргэжилтэн дангаар ажиллаад энэ асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь өргөн хүрээтэй ойлголт ба дараах чиглэлүүдийг өөртөө багтаадаг:

- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх

- Илрүүлэх, таслан зогсоох
- Хохирогчийг хамгаалах
- Хохирогч, гэр бүлийн гишүүдэд үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх
- Хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох, зан үйлд нөлөөлөх.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тогтолцоо нь дараах бүрдэл хэсэгтэй:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд
2. Хохирогчийг хамгаалах эрхзүйн орчин, цогц зохицуулалтууд
3. Салбар дундын зохицуулалтыг хангах механизм

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн нэг давуу тал нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бүхэлд нь тодорхойлж, байгууллага тус бүрийн бүрэн эрх, тэргүүлэн хариуцах чиглэл, төсвийг тодорхойлж баталгаажуулсан явдал юм.

Хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, мэргэжилтнүүд тогтолцоог бүхэлд нь харж, дангаар болон хамтдаа ямар чиг үүрэг хүлээж, тогтолцооны нэг хэсэг болж байгаага олж харах нь хамтын ажиллагаа, түншлэлийн суурь болно.

Хохирогчийг хамгаалах эрхзүйн цогц зохицуулалт

2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах цогц зохицуулалт бүрдсэн гэж үздэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон хохирогчийг хамгаалах үзэл баримтлал, суурь зарчмууд, хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаа, хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрлүүд болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо, бүтэц, механизм, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын чиг үүрэг зэргийг тодорхойлсон, урьдчилан сэргийлэх агуулгатай **суурь хууль** юм.

Харин хүчирхийллийн үйлдэл нь зөрчил, гэмт хэрэг, эсвэл иргэний хэрэг эсэхээс хамаарч хохирогчийг хамгаалах нарийвчилсан ажиллагаанууд нь бусад хуулиудад тусгагдсан байдаг. Тухайлбал, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиудаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зохицуулалтууд болон

хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлага нарийвчлан тусгагдсан.

Дээрх хуулийн холбогдох зохицуулалтуудыг сайтар судалж, хохирогч тус бүрийн хэрэгцээнд нийцүүлэн чадмаг ашиглаж чадсан тохиолдолд л хохирогчийн аюулгүй байдал болон амь нас, эрүүл мэнд бүрэн хамгаалагдаж чадна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх бодлого, арга хэмжээний зураглал



Алхам 2. Гэр бүлийн хүчирхийлэл, хохирогч хамгааллын талаар гарсан хууль эрхзүйн баримт бичгийн талаар асуух, хариулт өгч, батлагдан мөрдөгдөж байгаа эрхзүйн баримт бичгийг харуулж дахин сануулна.

СЭДЭВ 5. ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ ОРОЛЦОО

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль/ГБХТТХ/-ийн дагуу Эрүүл мэндийн яам, салбар байгууллагуудын удирдлагууд болон эмч, эмнэлгийн ажилтан дараах үүрэг, хариуцлагыг хүлээдэг.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу тус яам нь харьяалах нэг цэгийн үйлчилгээ, сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлж, эмнэлэгт ажиллах нэг цэгийн үйлчилгээний төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангахад гол үүрэг хүлээнэ. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлан, мэдээллийн сан бүрдүүлнэ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтыг зохион байгуулах үүрэгтэй.

Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох, мэргэжлийн дүгнэлт гаргах, нууцыг хадгалах, холбон зуучлах, хамтран ажиллах үүрэг хүлээж байгууллагадаа хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.



Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
(ГБХТТХуулийн 37 дугаар зүйл)



Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлж, заавал мэдээлнэ.
(ГБХТТХуулийн 23.1.2 дахь хэсэг)



Дараагийн шатны эмнэлэг, шинжилгээ оношилгоонд холбон зуучлах
(ГБХТТХуулийн 42 дугаар зүйл)



Хамтарсан багийн гишүүдтэй хамтран урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэх
(ГБХТТХуулийн 20 дугаар зүйл)

Бүхий л үйл явцын турш үйлчлүүлэгчийнхээ нууцыг хадгална.

Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсооход эмч, эмнэлгийн ажилтны үүрэг:

Тус хуулийн 23.1.2-д зааснаар “... эрүүл мэндийн, нийгмийн, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан...” Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар албан үүрэгтэйгээ холбоотойгоор олж мэдсэн бол цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад мэдээлэх үүрэгтэй:

Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор тус хуулийн 29.2-д зааснаар “Бүх шатны боловсролын байгууллагын багш, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтан нь хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгаж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох үүрэгтэй.

Эрүүл мэндийн ажилтны хохирогчийг хамгаалах үүрэг:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу дараах үүрэг хүлээнэ:

Хуулийн 27.1. Эрүүл мэндийн ажилтан хохирогчийг хамгаалах талаар дараах үүргийг хүлээнэ:

27.1.1. эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах;

27.1.2. хохирогчийг шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллээр хангах;

27.1.3. энэ хуульд заасан үүргийг хэрэгжүүлэх ур чадвар эзэмших чиглэлээр сургалтад хамрагдах;

27.1.4. хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллах, мэргэжлийн дүгнэлт гаргах;

Хуулийн 27.2. Энэ хуулийн 27.1.4-т заасан үүргийг өрхийн эмч, шаардлагатай тохиолдолд бусад эмч гүйцэтгэнэ.

Хохирогчид үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийллийн хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлэхээр заасан.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.5, 24.6.8-д аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврах явцад гэмтсэн, өвчилсөн иргэнд үзүүлэх болон бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээний зардлыг төрөөс хариуцахаар заасан.

**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 37 дугаар зүйл.
“Эмнэлгийн тусламж, үйлчилгээ”**

Тус хуулийн 37.1. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн хохирогчид Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.7-д заасан үйлчилгээг үзүүлнэ.

37.2.Эмнэлгийн яаралтай тусламжаас бусад үйлчилгээг хохирогчийн байнга, эсхүл түр оршин сууж байгаа газрын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, хэрэв хохирогч эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд байгаа бол уг байгууллагын оршин байгаа газрын нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ.

37.3.Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тус хуулийн 38 дугаар зүйлийн дагуу хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлнэ.Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

Яаралтай тусламж, үйлчилгээ – Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4.1.4, 4.1.5-д зааснаар эрүүл мэндийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг хохирогчийн оршин суух харьяалал болон хүчирхийлэл дөнгөж сая үйлдэгдсэн эсэх, хохирогч эрүүл мэндийн даатгалтай, эсхүл иргэний бичиг баримттай эсэхийг үл харгалзан үзүүлнэ.

Нөхөн сэргээх тусламж үйлчилгээ- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4.1.7-д заасны дагуу “Өвчин эмгэг, бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ” үзүүлнэ.

Эмч, эмнэлгийн ажилтныг чадавхжуулах үйлчилгээ

Хохирогчийн гэр бүлийг сэтгэл заслын, нөхөн үржихүйн, асаргаа, сувилгааны, зөв дадал, зуршил хэвшүүлэх, эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар чадавхижуулах үйлчилгээ үзүүлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А\394 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

- ✓ Тус журам нь гэр бүлийн хүчирхийлэлд бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хэлбэрээр өртсөн хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор илрүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

- ✓ Журмаар хохирогчийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулах зохион байгуулалт, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын эрх, үүрэг, эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх үүрэг, хохирогчийн эрх, үүргийг тодорхойлж, тайлан, мэдээ солилцох урсгалыг тогтоосон. Үүнд:

Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын эрх, үүрэг

1. Хохирогчийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, цагдаагийн байгууллага иртэл түр хамгаалан аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад байгууллагынхаа тасаг, нэгжийн үйл ажиллагааг уялдуулан, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах,

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, осол, гэмтэл, өвчлөлд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөөллийг судлах, хүчирхийллийн шалтгаант осол, гэмтэл, өвчлөлийг бууруулахад чиглэсэн зөвлөмж мэдээллийг түгээх,

3. Эрүүл мэндийн байгууллага өөрийн хөдөлмөрийн дотоод журам, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтонд гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, нууцлалыг хамгаалах, мэдээлэл өгөх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, багаар ажиллах үүргийг тусгах,

4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг тогтмолжуулах

5. Хохирогчийн нууцыг хадгалах, хамгаалах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлэх.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх үүрэг

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний улмаас эрүүл мэндээ хамгаалуулах иргэний хүсэлт, хүчирхийллийн болзошгүй эрсдэл учирсан байх магадлалтай гэж үзвэл нас хүйс харгалзахгүй, бичиг баримт шаардахгүй, дугаар, харьяалал харгалзахгүй, харгалзан авч яваа хүнээс тусгаарлан үзлэг хийх

2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, цагдаагийн байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах

3. Албан үүргээ гүйцэтгэж байсантай холбоотойгоор олж мэдсэн хохирогчийн талаарх мэдээлэл, хамгаалах байрны байршлын нууцлалыг ханган, задруулахгүй байх

4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, мэдээлэх, баримтжуулах, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, нийгмийн ажилтантай хамтран ажиллах, ур чадварыг эзэмших, дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтад хамрагдах

Хохирогч хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ

1. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ өөрт нь болон эцэг, эх, асран хамгаалагчид үзлэгийн талаар мэдээлэл өгч, тайлбарлан ойлгуулсны үндсэн дээр бүтэн биеийн үзлэг хийнэ. Шаардлагатай тохиолдолд ганцаарчлан ярилцаж, үзлэг хийнэ.

2. Хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй, өртөх эрсдэлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэдтэй эелдэг харилцаж, хүндэтгэлтэй хандах, хүүхэдтэй ярилцах үедээ хүүхдийн хөгжил, сэтгэл зүй, насны онцлогт тохирсон энгийн үг, хэллэг хэрэглэх, хүүхдэд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, хүүхдийг буруутгасан үг хэлэх, хандлага, үйлдэл гаргахгүй байх зарчим баримтлана.

3. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийг цагдаагийн албан хаагч, хамтарсан баг, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагад заавал өгнө.

4. Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа талаар хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүдэд тайлбарлан таниулна.

5. Хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг стандарт, зааврын дагуу үзүүлэн баримтжуулна.

6. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд яаралтай болон бусад эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсний дараа тусгай хамгаалалтаар хангах эрх бүхий байгууллагын албан хаагчид дахин мэдэгдэж, хүлээлгэн өгнө.

Хүчирхийллийн хохирогчийг үзэхэд эмч, эмнэлгийн ажилтан анхаарах зүйлс:

1. Гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагддаг гэдгийг байнга санах,
2. Гэр бүлийн дотоод асуудал гэж хохирогч гэмтэл бэртэлээ нуудаг.
3. Хохирогч нь асуумжинд санаатайгаар худал мэдээлэл өгдөг.
4. Хохирогч нь бусдаас хараат, сэтгэл санаа болон бусад байдлаар дарамтад орсон байдаг.
5. Эмнэлэгт үзүүлэх явцад хохирогчийг хүчирхийлэгч ихэнхдээ дагаж явж, байнга цуг байх сонирхолтой байдаг тул түүнээс тусгаарлан тусад нь үзлэг хийж, асуумж авах, нууц хадгалах.

Зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүд

Гэр бүлийн хүчирхийлэл нь олон талт үр дагаврыг хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд авчирдаг тул хүчирхийллийг даван туулахын тулд цогц үйлчилгээ, тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд хохирогчийн хөндөгдсөн эрх, тусгай

болон өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн дараах үйлчилгээний төрлүүдийг анх удаа баталгаажуулан хуульчилсан.

Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандана. Үйлчлүүлэгч тус бүрийн бие даасан байдал, хувийн онцлог, соёлын өвөрмөц байдал, ялгаатай хэрэгцээг харгалзана.

Хохирогчдод үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, жирэмсэн эмэгтэй, ахмад настны хэрэгцээ, шаардлагыг харгалзана. Монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ орчуулагч, хэлмэрчийн тусламж авах боломжоор хангана.

Зураг 3. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрлүүд

1. Аюулгүй байдлын хамгаалалт	<ul style="list-style-type: none"> • Түр хамгаалан байрлуулах • Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх • Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулах
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах • Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллах, мэргэжлийн дүгнэлт гаргах
Сэтгэл зүйн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Сэтгэл зүйн зөвлөгөө • Сэтгэл заслын үйлчилгээ
Нийгмийн халамжийн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний холбогдох төрлүүд (Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1 дэх зүйл)
Хүүхэд хамгааллын үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах • Хүүхэд хамгаалалтын тухай хуульд заасан үйлчилгээ
Эрх зүйн тусалцаа	<ul style="list-style-type: none"> • Эрхзүйн зөвлөгөө • Өмгөөллийн үйлчилгээ
Холбон зуучлах үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн ажилтны хийсэн Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн холбон зуучилсан.

Хохирогчид үзүүлэх дээрх 7 төрлийн үйлчилгээг холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран үзүүлэх, үйлчилгээний талаарх мэдээллийг солилцох үүрэгтэй¹⁰. Холбон зуучлах үйлчилгээ болон байгууллага хоорондын мэдээлэл солилцоо нь хохирогч, даван туулагчийн зүгээс өөрт тохиолдсон зүйлээ олон дахин ярих эрсдлийг багасгаж, ингэснээр үйлчлүүлэгч сэтгэлзүйн цочролд дахин өртөхөөс урьдчилан сэргийлдэг.

10 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт

Хохирогчийг нутаг дэвсгэрийн харъяалал харгалзахгүйгээр Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан бусад үйлчилгээг 24 цагийн турш нэг дор үзүүлэх чиг үүрэг бүхий нэгж нь эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад ажиллана.

Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын үүрэг, оролцоо

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад дагалдан гарсан хуультай нийцүүлэн хүчирхийлэлд өртсөн хүнд, ялангуяа бүх эмэгтэйчүүд, охидод үзүүлэх нэн шаардлагатай, чанартай, уялдаа холбоо бүхий олон салбар\цагдаа, нийгмийн халамж, боловсрол гэх мэт\ -ын хамтарсан “Нэн шаардлагатай үйлчилгээний нэгдсэн багц”-ыг боловсруулан салбар бүр удирдамж болгон мөрдөж байна. Энэ нэгдсэн багцад **эрүүл мэндийн нэн шаардлагатай үйлчилгээний багц багтдаг.**

Жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрүүдийн үед ялангуяа охид, эмэгтэйчүүдэд хэрэгтэй нэн шаардлагатай үйлчилгээг эрүүл мэндийн анхан шатны байгууллагыг түшиглэн зохион байгуулж, энэхүү арга хэмжээнд эрүүл мэндийн бүх байгууллагууд харилцан уялдаатай, зохион байгуулалттайгаар оролцож, үүрэг хариуцлага хүлээж, нийгмийн бусад холбогдох салбаруудтай хамтран ажиллах шаардлагатай юм.

Хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээг чанартай үзүүлэх нь үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтаас нилээд шалтгаалах ба байгууллагадаа эрүүл мэндийн нийтлэг үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байдгийг бусад орны туршлага харуулдаг.

Хүчирхийлэлд өртсөн хохирогч\охид, эмэгтэйчүүдийг илрүүлж, оновчтой тодорхойлж, эмчлэхээс гадна эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэх боломжтой байлгах, цочролоос үүдэлтэй сэтгэл санааны гэмтлийг эмчлэх үйлчилгээ нь **үр дүнтэй, үнэ төлбөргүй, аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй, чанартай** байх нь хохирогчид бий болох сөрөг үр дагавраас хамгаалах боломжийг бүрдүүлдэг.

Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс гадна эмнэлгээр үйлчлүүлээгүй хохирогчийг илрүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ, гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналт, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, архи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах тэмцэх бусад нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ бас хамаардаг. Энэ нь нийгмийн зөв хэм хэмжээ тогтоох, хүчирхийллийг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулах бөгөөд үүнд олон нийтийг дайчлах, болон бусад салбар байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, оролцох шаардлагатай.

Бүх түвшний эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагад хүчирхийлэлд өртсөн хохирогчид/эмэгтэйд үзүүлэх анхан шатны тусламж, үйлчилгээнд урьдчилан сэргийлэх үйлчилгээ, эмчилгээ үйлчилгээ, хөнгөвчлөх үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанууд багтах аас гадна төрийн болон төрийн бус байгууллагуудаар үзүүлж буй бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, үүнд: эхийн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, үр хөндүүлсний дараах асаргаа тусламж, ДОХ/ХДХВ-ийн тусламж үйлчилгээ болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ багтдаг.

ЭМАШТУ, жишээ нь эрүүл мэндийн постууд, эрүүл мэндийн төвүүд, диспансер, амбулаториар эрүүл мэндийн ерөнхий үйлчилгээ үзүүлдэг, зарим зайлшгүй наад захын үйлчилгээг хэвтэж эмчлүүлдэг дүүргийн эмнэлгүүд, гэх мэт.

Эрүүл мэндийн бусад үйлчилгээнд холбон зуучлах, үүнд тусгай мэргэжлийн эмч нартай гуравдах шатны эмнэлэгүүдтэй холбон зуучлах үйлчилгээ багтана.

Олон салбарын хамтарсан нэн шаардлагатай нэгдсэн үйлчилгээнүүдэд бэлгийн хамтрагчийн болон бусад хүний үйлдсэн бэлгийн хүчирхийллийн хохирогч эмэгтэй, охид, хүүхдийн хүний эрх, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг ханган хамгаалахад чиглэсэн үйлчилгээний хамгийн наад захын үйлчилгээнүүд багтах эдгээр нь үйлчилгээг хүртэх боломжтой эсэх, үйлчилгээний уян хатан, зохистой байдал, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нууцлалыг хадгалах, үр дүнтэй харилцаа холбоо тогтоох, мэдээллийн удирдлагыг хангах, холбон зуучлах арга хэмжээ багтдаг.

Эрүүл мэндийн нэн шаардлагатай багцад хосуудын хүчирхийллийн хохирогчийг тодорхойлох, анхны тусламжийн үйлчилгээ, гэмтэл бэртэл, эрүүл мэндийн үйлчилгээ, бэлгийн хүчирхийллийг шалгах, хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийн үнэлгээ ба тусламж, баримт нотолгоожуулах (шүүх эмнэлгийн) зэрэг үйлчилгээнүүд багтана.

Хосуудын хүчирхийллийн хохирогчийг тодорхойлох.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал нь хүчирхийллийн шалтгаантай эсвэл хүчирхийллийн улмаас хүндэрсэн байж болохыг ойлгож байх нь чухал байдаг. Бэлгийн хамтрагчийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд нь сэтгэлзүйн эсвэл биеийн ямар нэг өөрчлөлтийн улмаас, тухайлбал, гэмтэл бэртэл зэрэг шалтгаанаар эрүүл мэндийн үйлчилгээнд ханддаг. Гэсэн хэдий ч тэд үйлчилгээ үзүүлэгчдэд хүчирхийллийн талаар хэлдэггүй. Учир нь бусдаас ичих, айх эсвэл бэлгийн хамтрагчаасаа айх айдастай байдаг тул маш болгоомжтой, зөв асуулт тавьж дараах аргаар харилцана:

I. Мэдээлэл цуглуулах - Бэлгийн хамтрагчийн болон бусдын зүгээс үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн талаар мэдээллийг бичгэн хэлбэрээр эрүүл мэндийн байгууллагуудад байрлуулах, тухайлбал ханын календар, гарын авлага хэлбэрээр байрлуулах, ингэхдээ эмэгтэйчүүд ганцаараа байх боломжтой байршлуудад, тухайлбал эмэгтэйчүүдийн бие засах газар, угаалгын өрөөнд байрлуулсан байх шаардлагатай (ингэхдээ бэлгийн хамтрагч нь хамт амьдардаг тохиолдолд гэр рүүгээ авч очиж болохгүйг анхааруулсан байх)

II. Бэлгийн хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн хохирогч\ эмэгтэйчүүдийг тодорхойлох - эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь эмэгтэйгээс бэлгийн хамтрагчийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг асуух шаардлагатай ба ингэснээр үйлчлүүлэгчид үзүүлэх халамж үйлчилгээ нь сайжрах юм. Эмэгтэйчүүдээс хүчирхийллийн талаар асуухдаа үр дүнтэй хариу арга хэмжээтэй холбогдсон байх шаардлагатай, үүнд: анхан шатны нэгж дээр дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээнүүдэд зуучлах эсвэл бусад үйлчилгээнд зуучлах зэрэг болно.

“Хүн бүрээс асуух нийтлэг асуултууд” буюу “зайлшгүй асуух асуултууд”-ыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. (жишээ нь эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж буй бүх эмэгтэйчүүдээс асуух) Ингэснээр хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг илрүүлэх илрүүлэлт нэмэгдэхээс гадна эрүүл мэндийн үр дүн ба холбон зуучлах үйлчилгээг сайжруулдаг. Гэхдээ хөрөнгө нөөц хязгаарлагдмал, холбон зуучлах үйлчилгээ байхгүй тохиолдолд үүнийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэйг анхаарах хэрэгтэй.

Эрүүл мэндийн тогтолцоо нь эмэгтэйгээс хүчирхийллийн талаар асууж эхлэхээсээ өмнө хувийн нууцлалыг хангасан байх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь зохих ёсоор бэлтгэгдсэн байх, хэрхэн хариу арга хэмжээ авах талаар мэдлэгтэй байх, холбон зуучлах үйлчилгээг бий болгох, үйл ажиллагааны талаар протокол/стандартууд боловсруулагдсан байх зэрэг наад захын шаардлагыг хангасан байх ёстой.

Эмэгтэйг хүчирхийлэлд өртөж байгаа гэж сэжиглэж байгаа тохиолдолд хугацаа алдалгүй, нэн даруй арга хэмжээ авч боломжит үйлчилгээнүүдийн талаар мэдээлэл өгөх, эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндэд учрах хүчирхийллийн хор хөнөөлийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, дараа дахин ирэхийг санал болгох хэрэгтэй.

2. Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх

Эрүүл мэндийн анхан шатанд үзүүлэх үйлчилгээний хэрэгцээ шаардлага нь хохирогчдод ихэнхдээ хамгийн чухал дэмжлэг байдаг бөгөөд анхан шатны дэмжлэг нь эмэгтэйн сэтгэл санаа, бие махбодь, аюулгүй байдал болон бусад дэмжлэг туслалцааны хэрэгцээ шаардлагыг хувийн нууцад нь халдалгүйгээр тодорхойлоход чиглэдэг. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйдүүдэд дэмжлэг үзүүлэхдээ дараах дөрвөн төрлийн хэрэгцээнд анхаарлаа хандуулна. Үүнд:

1. Сэтгэлзүйн ба сэтгэцийн эрүүл мэндийн нэн шаардлагатай хэрэгцээ
2. Эрүүл мэндийн нэн шаардлагатай хэрэгцээ
3. Аюулгүй байдлыг хангах хэрэгцээ
4. Байнгын дэмжлэг болон сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээ

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид нь дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- а. Зөвлөгөөг өгөхдөө хувийн нууцыг хангасан орчинг бүрдүүлсэн байх
- б. Мэдээллийн нууцыг хадгалах талаар танилцуулахдаа түүний хязгаарлагдмал талуудыг танилцуулах (ж.нь: зайлшгүй мэдээлэх үүргийг).
- в. Эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэгч нь анхан шатны дэмжлэг үзүүлэх боломжгүй бол өөр бусад байгууллагуудаас нэн даруй авах байдлаар зохион байгуулна. (эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага дотроосоо эсвэл бусад хүртээмжтэй газруудаар дамжуулна)
- г. **Зайлшгүй мэдээлэх** Эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэгчид эмэгтэйчүүдийн хүчирхийллийн талаар хуулийн дагуу цагдаад эсвэл Засаг даргад мэдээлнэ. Учир нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох байгууллагуудад, тухайлбал цагдаад мэдээлэхийг эмэгтэйд санал болгох шаардлагатай ба зөвхөн эмэгтэй зөвшөөрсөн тохиолдолд болон эмэгтэй өөрийнхөө эрхийг мэдэж байгаа тохиолдолд л мэдээлэх үүрэгтэй байх нь тохиромжтой. Хуулинд шаардсан тохиолдолд, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэгч нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон хэн нэгний амь насанд аюултай үйлдлүүдийг холбогдох байгууллагуудад заавал мэдээлэх үүрэгтэй.

3. Гэмтэл бэртэл, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх

Эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ сэтгэлзүйн үйлчилгээтэй хамт үзлэг хийж, хамтад нь авч үзэх шаардлагатай. Үйлчилгээнүүд нь стандарт, шаардлагыг хангасан дараах үйлчилгээнүүдэд хуваагдана.

- I. **Өмнөх түүхийг тодорхойлох, эрүүл мэндийн үзлэг хийх** - Хүчирхийллийн талаарх түүхийг тэмдэглэхдээ эрүүл мэндийн стандарт процедурыг дагана. Гэхдээ бэлгийн хамтрагчийнхаа болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд сэтгэлзүйн цочролд орсон байх магадлалтай анхаарах хэрэгтэй. Иймээс тухайн эмэгтэйд ямар нэг бичиг баримт байгаа эсэхийг анзаарч, хариулсан асуултыг дахин асуухаас зайлсхийх шаардлагатай. Эрүүл мэндийн үзлэг хийх, эмчилгээ хийх, шүүх эмнэлгийн нотолгоо цуглуулах, мэдээллийг гуравдагч этгээдэд жишээлбэл цагдаа шүүхэд өгөх, хэрэв эмэгтэй нотолгоо цуглуулахыг хүсвэл энэ чиглэлээр бэлтгэгдсэн үйлчилгээ үзүүлэгчид зуучлах, эрүүл мэндийн үйлчилгээг нягт нямбай хийх үзлэгийн үр дүн болон тэмдэглэгээг маш тодорхой тэмдэглэх, эрүүл мэндийн үйлчилгээ үе шат бүрээр тодорхой тайлбарлаж эхлээд зөвшөөрөл авахад мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрлийн маягтийн талаар тайлбарлаж зөвшөөрөл авна.
- II. **Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх**-Хэрэв эмэгтэй амь насанд аюултай эсвэл хүнд нөхцөлд байвал нэн шаардлагатай яаралтай тусламжид нэн яаралтай зуучлах

4.Бэлгийн хүчирхийллийг шалгах, дэмжин туслах үйлчилгээ

Бэлгийн хүчирхийлэл нь сэтгэлзүйн цочролд хамгийн их оруулдаг бөгөөд эмэгтэйн сэтгэц, биемахбодид болон бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндэд төрөл бүрийн сөрөг нөлөөг үзүүлдэг. Энэ нь хурц хэлбэрээр илэрч болох ба урт хугацааны сэтгэцийн эрүүл мэндийн асаргаа эмчилгээг шаарддаг.

- I. **Түүх цуглуулах** - ямар үйлчилгээ хэрэгтэйг тодорхойлохын тулд эмэгтэйн ярьсан өмнөх түүхийг бүрэн цуглуулах, бүртгэх, бие махбодын бүрэн үзлэг хийх (хөлөөс толгой хүртэл болон бэлэг эрхтний үзлэг хийх). Эмэгтэйн түүх нь ямар төрлийн хүчирхийлэлд өртсөн болон түүнээс хойш ямар хугацаа өнгөрсөн, жирэмслэх эрсдэлтэй эсэх, ХДХВ болон бусад бэлгийн замын өвчин авах эрсдэлүүд, сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл байдал зэрэг мэдээллийг багтаасан байна.
- II. **Яаралтай тусламжийн багцад байх жирэмслэхээс хамгаалах эм хэрэгсэл** - Бэлгийн хүчирхийллийн хохирогчид хүчирхийлэл үйлдэгдсэнээс хойш 5 өдрийн дотор эмнэлэгт хандсан тохиолдолд жирэмслэхээс хамгаалах эмийг яаралтай

уухийг санал болгоно. Эм хэрэгслийн үр нөлөөг сайжруулахын тулд хүчирхийллийн дараа аль болох хурдан хугацаанд санал болгох шаардлагатай. Хэрэв эмэгтэй хүчирхийлэл үйлдэгдсэнээс хойш 5-аас дээш өдрийн дараа эмчид хандсан эсвэл яаралтай үеийн жирэмснээс хамгаалах хэрэгсэл үр дүнгүй болсон эсвэл эмэгтэй хүчирхийллийн улмаас жирэмсэн болсон тохиолдолд эмэгтэйд аюулгүй үр хөндүүлэх үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу шийднэ.

III. **ХДХВ-н халдвар авсан үед авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ** - бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэний дараа 72 цагийн дотор үйлчилгээнд хандсан эмэгтэйд ХДХВ-н халдварын эсрэг арга хэмжээг санал болгоно. Ингэхдээ хохирогчтой хамтран шийдвэр гаргах аргыг ашиглан тухайн арга зохимжтой эсэхийг шийдэх ба урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан үндэсний удирдамжийг баримтална.

IV. **Бэлгийн замын халдвараар халдварласан тохиолдолд авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ** - бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйд бэлгийн замын нийтлэг халдварт өвчнүүдээс хамгаалах тухай болон гепатит В вирусийн эсрэг вакцин хийлгэх зэрэг асуудлыг үндэсний хууль тогтоомж, журмын дагуу хийлгэхийг санал болгоно.

5.Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ ба асрамж

Бэлгийн хамтрагчийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн олон эмэгтэйд сэтгэцийн болон сэтгэл санааны олон асуудлууд илэрдэг. Хүчирхийлэл болон дарамттай нөхцөл байдал арилсаны дараа сэтгэцийн асуудал илааршина. Ихэнх хүмүүс яваандаа бүрэн эдгэрдэг. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь эмэгтэйн стресс, сэтгэл гутралыг бууруулах, эрүүл болох үйл явцыг дэмжих туслах хэд хэдэн аргууд байдаг. Зарим эмэгтэй бусдаас хүнд хэлбэрийн сэтгэлзүйн хямралд өртдөг. Иймээс эдгээр зүйлсийг тодорхойлж тэдэнд шаардлагатай асаргаа үйлчилгээг авахад нь туслах нь чухал.

I. **Бэлгийн хамтрагчийн хүчирхийллийг даван туулагчдад үзүүлэх асаргаа үйлчилгээ** - хүчирхийлэлд өртсөн эмэгтэйн сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ (стресс цочирлын дараах цочролт үйлдлийн дараах стресс, сэтгэл гутрал, архи болон хар тамхи хэрэглэх, амиа хорлох талаарх бодол гэх мэт шинж тэмдгүүдийг заавал үнэлэх шаардлагатай. Дэлхийн сэтгэцийн

эрүүл мэндийн байгууллагын нотолгоонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний клиникийн протоколд заасан удирдамжийн дагуу эмчилнэ. Сэтгэцийн эрүүл мэндийн асаргаа үйлчилгээг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ойлголт мэдлэг сайтай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хүргэнэ.

- II. **Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг** - Хүчирхийллийн дараа 1-3 сар нийгэм сэтгэлзүйн үйлчилгээг үзүүлнэ. Нийгэм сэтгэлзүйн дэмжлэгт тухайн эмэгтэйд асуудлыг зөв шийдэх ур чадвараа бэхжүүлэхэд нь туслах, боломжит нийгмийн дэмжлэгүүдийг илрүүлэх, хайж өгөх, стресс бууруулах аргыг хэрэглэх, хийлгэх, байнга хяналтанд байх дэмжлэгт үйлчилгээ зэрэг багтана.
- III. **Сэтгэцийн эрүүл мэндийн хүнд хэлбэрийн асуудлууд** - Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг хийх явцдаа амиа хорлох, бэртэл, дунд зэргийн болон хүнд хэлбэрийн сэтгэл гутрал цочролт үйлдлийн дараах сэтгэл гутралын шинж байгаа эсэхийг үнэлж, бие махбодын үзлэгтэй хамт хийнэ, стресс бухимдлаа удирдах аргад сургах, мөн боломжтой бол мэргэжлийн сэтгэл зүйчид хандахыг санал болгож зуучлах, шаардлагатай бол сэтгэлзүйн эмчилгээний эсхүл танин мэдэхүйн зан үйлийн сэтгэл засалд зуучилна.
- IV. **Эмэгтэйчүүд төвтэй асаргаа халамж** – Бэлгийн хамтрагчийн (эсвэл гэр бүлийн) хүчирхийлэлд өртсөн эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд нэн шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь дор хаяж наад захын тусламж дэмжлэгийг санал болгох шаардлагатай. Анхан шатанд үзүүлэх тусламж дэмжлэг гэдэгт эмэгтэйг буруутгахгүйгээр түүний хэлж буйг баталгаажуулах, эмэгтэйн санаа зовниж байгаа чиглэлээр асаргаа дэмжлэгийг үзүүлэх, ингэхдээ бие даан шийдвэр гаргах эрхийг нь хүндэтгэх, хүчирхийллийн түүхийн талаар асууж анхааралтай сонсох, гэхдээ цааш нь ярихыг хүчилж болохгүй (эмзэг сэдвээр ярилцахдаа маш анхааралтай сонсох, тохиолдолд орчуулагч оролцуулах шаардлагатай). Эмэгтэйгээс мэдээлэл авахдаа асууж байцаалгүйгээр сонсох, мэдээллийг санал болгох, үүнд: эмэгтэйд боломжит нөөц боломжууд, тухайлбал хууль эрхзүйн болон бусад үйлчилгээний талаар мэдээлэл өгөх. Эмэгтэйг бусад болон нийгмийн дэмжлэгтэй холбогдоход нь

туслах, хүнд хэлбэрийн стрессийн хэрхэн зохицуулах стратегийн талаар мэдээллийг бичгээр өгөх(ингэхдээ хүчирхийлэгч хамт байгаа тохиолдолд гэр лүүгээ авж явж болохгүйг анхааруулах), шаардлагатай тохиолдолд өөрийнхөө болон хүүхдийнхээ аюулгүй байдлыг хангахад нь туслах, сэтгэл санааны хямралыг бууруулахад нь тусалж, тайван байдлыг нь хангах, нийгмийн дэмжлэгээр хангах (бусад үйлчилгээтэй холбон зуучлах).

6.Баримтжуулах\шүүх эмнэлгийн үйлчилгээ

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчтэй ярилцсан бүх асуудлаа тэмдэглэх үүрэгтэй байдаг. Тэмдэглэлийг хийхдээ өвчтөний хэлсэнээр өөрийнх нь үгээр бичихээс гадна өөрийн харсан ажигласан зүйлсийг үзлэгийн дэвтэр, журналд тэмдэглэнэ. Үзлэг хийхдээ үнэн бодитой бүрэн тэмдэглэл хийх нь дараа хэргийг шүүхэд нотолгоо бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хэрэв эмэгтэй шүүх эмнэлгийн үзлэгт хамрагдахыг зөвшөөрвөл албан ёсны байгууллагууд руу утасдаж зуучлах шаардлагатай.

- I. **Бүрэн, үнэн, бодитой мэдээлэл бүрдүүлэх баримтжуулах** – Эрүүл мэндийн дэвтэрт эрүүл мэндийн асуудлуудын шинж тэмдэгүүд болон эмэгтэйн гэмтэл бэртлийн талаар тэмдэглэнэ. Эмэгтэйн эрүүл мэндийн талаар болон үүссэн асуудлын шалтгааны талаар бичих хэрэгтэй байдаг.Эмэгтэйгээс энэ мэдээллийг эрүүл мэндийн дэвтэрт оруулж болох талаар зөвшөөрөл авна. Эмэгтэйн хүслийг дагана.
- II. **Шүүх эмнэлгийн нотолгоо цуглуулах баримтжуулах** - Эмэгтэй шүүх эмнэлгийн нотолгоо цуглуулахыг зөвшөөрсөн тохиолдолд нотолгоонуудыг цуглуулж, маш тодорхой хаягжуулах шаардлагатай.
- III. **Бичгээр нотолгоог гаргах шүүх хуралд орох** - Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль эрхзүйн талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй, үүнд: мэдээллийг хэрхэн бичих, гэмтэл бэртлийг баримтжуулах, гэмтэл бэртлийг бүрэн үнэн, зөв тодорхойлж, баримтжуулах, эмнэлзүйнажиглалтыг хийх, хохирогчоос хэрхэн дээж авсан талаар гэх мэт.

СЭДЭВ 6. ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ САЛБАР ДУНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны ҮНДСЭН зарчим нь салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, үйл ажиллагаа нь нэгдмэл, цогц байх юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан тэмцэх асуудлыг тусгасан.Түүнчлэн тус хуулинд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог хуульчилж, оролцогч талууд, тэдгээрийн үүрэг хариуцлагыг маш тодорхой ялган зааглаж өгсөн.

Хуулинд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар бодлогын түвшинд, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглэл өгөх, хяналт тавих чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

Бодлогын буюу Үндэсний түвшинд	ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл,
Хэрэгжилтийн түвшинд буюу Орон нутгийн түвшинд	Засаг даргаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл,
Салбар дундын үйлчилгээ	Хамтарсан баг, Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр

Хамтарсан баг

Засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороон дээр зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүдийг үзүүлэх үүрэг бүхий сум, хорооны Засаг даргаар ахлуулсан хамтарсан баг ажиллана. Хамтарсан баг нь дараах төлөөллөөс бүрдэнэ:

- ✓ сум хорооны Засаг дарга
- ✓ өрхийн эмч
- ✓ сум, хорооны ажилтан
- ✓ гэр бүлийн хөгжлийн, халамжийн, нийгмийн ажилтан
- ✓ цагдаагийн алба хаагч
- ✓ сургуулийн
- ✓ халамжийн ажилтан
- ✓ энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ

Хамтарсан баг нь төрийн анхан шатны мэргэжилтнүүдээс бүрдсэн мэргэжлийн баг бөгөөд хуулиар хүлээсэн үүргийн дагуу гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээг цогцоор үзүүлдэг мэргэжилтнүүдээс бүрдсэн баг юм. Багаар үйлчилгээ үзүүлэх нь мэргэжилтнүүд хоорондын ажлын уялдаа холбоог хангах, үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Хамтарсан багийн үүрэг:

- ✓ Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
- ✓ Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх
- ✓ Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- ✓ Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;
- ✓ Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
- ✓ Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

Хамтарсан багаар ажиллах зарчим: Хамтарсан баг нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг баг бөгөөд доорх зарчмуудыг баримтлан ажиллана. Хамтарсан багийн гишүүд хувь хүн, гэр бүлд үзүүлэх үйлчилгээндээ дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- ✓ Аливаа хүнтэй хувь хүнийх нь хувьд нэр төр, үнэ цэнэ, онцлог байдалд нь хүндэтгэлтэйгээр хандах
- ✓ Хохирогчийн өөрөө өөрийгөө тодорхойлох, өөрийнхөө амьдралд хамаатай асуудлаар шийдвэр гаргах, өөрийгөө төлөөлөх жам ёсны эрхийг хангах, гаргасан шийдвэрийг нь хүндэтгэх
- ✓ Үйлчлүүлэгчийг анхааралтай сонсох, тайтгаруулах, үл шүүмжлэх, хүлээцтэй, соёлтой хандах

- ✓ Харилцан итгэлцэл, хүндлэлд тулгуурласан хамтын ажиллагааны түншлэлийн үзэл санаагаар үйлчлүүлэгчтэй харьцах, хохирогч төвтэй үйл ажиллагаа явуулах
- ✓ Нэн тэргүүнд хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдалд гол анхаарлаа хандуулах
- ✓ Бодит байдлыг ойлгох, асуудалд мэдрэмжтэй хандах /итгэх, үйлчлүүлэгчид эргэлзээ төрүүлэхгүй байх, худал ярьсан ч буруутгахгүй байх/
- ✓ Хүнийг нас, хүйс, нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээл, итгэл үнэмшил, үзэл бодол, бэлгийн чиг баримжаа, эдийн засгийн боломж болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй, тэгш хандах
- ✓ Нууцыг чандлан хадгалах
- ✓ Олон салбарын мэргэжилтнүүд хамтарч байгааг харгалзан цаг баримтлах, багийн өмнө хүлээсэн үүргээ мэргэжлийн түвшинд хугацаанд нь гүйцэтгэх
- ✓ Хүчирхийллийн болзошгүй эрсдэл үүссэн тохиолдолд хохирогчийн болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авахдаа Хамтарсан багийн гишүүд мэдээллийн нууцыг чандлан хадгалж, зөвхөн түүнийг мэдэх шаардлагатай гэсэн албан тушаалтнуудад л хүргэнэ.
- ✓ Үйлчлүүлэгчид итгэл хүлээлгэх, амгалан тайван байдал болон нууцаа хамгаалуулах эрхийг хангаж, хувийн зорилго, хариуцлага, онцлогийг хүлээн зөвшөөрнө.
- ✓ Үйлчлүүлэгчийн бие даасан хариуцлагатай шийдвэр гаргахад туслах бөгөөд бүх үйлчлүүлэгчдэд тэгш хандана. Мэргэжлийн үйлчилгээг дээрхи байдлаар үзүүлж чадахгүй тохиолдолд энэ тухай үйлчлүүлэгчид мэдээлж, сонголт хийх боломж олгоно.
- ✓ Үйлчлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээж, бусдын ёсзүйн шаардлагын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- ✓ Хамтарсан багийн үйлчилгээнд хэрэглэгдэх маягт, “Нууц”-ын гэрээний загварыг ашиглах нь үйл ажиллагаанд хэрэгтэй.

Нэг цэгийн үйлчилгээний төв

Монгол Улсын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 5.1.3–д зааснаар “Нэг цэгийн үйлчилгээ” гэдэг нь эмнэлэг, төрийн болон ТББ-ууд түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг дор үзүүлэх ажиллагааг хэлнэ.

Нэг цэгийн үйлчилгээний төв \цаашид НЦҮТ гэх\ нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдийг хүчирхийлэл дарамтанд өртсөнийг эрт шатанд илрүүлж, таслан зогсоохын тулд аюулгүй, хамгаалагдсан орчинд бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн багийн цогц үйлчилгээг цаг алдалгүй чанартай, нэг цэгээс үзүүлэх зорилготой.

Нэг цэгийн үйлчилгээ нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэнд харъяалал харгалзахгүй, тусламж, үйлчилгээг 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлнэ.

Нэг цэгийн үйлчилгээний төв нь хохирогчийг ялгаварлан гадуурхахгүй байх, хохирогч төвтэй, эрхэд суурилсан үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нэн тэргүүн ээлжинд үйлчилгээ үзүүлэх зарчмыг баримтална.

Нэг цэгийн үйлчилгээний төв нь нууцыг хадгалах үүрэгтэй. Мөн хохирогчийн хүсэл, сонирхол, хүний эрх, нэр төрийг болон хүүхдийн эрх ашгийг дээдлэн хүндэтгэнэ.

Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнууд нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, сэтгэлзүйч, эрхзүйч нь эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Нэг цэгийн үйлчилгээний төвийн зардал нь орон нутгийн төсөв болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Засаг дарга нар дараа жилийн төсөвтөө тусгах үүрэгтэй.

Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хохирогч дараах эрх, үүрэгтэй:

- ✓ Анхан шатны болон яаралтай тусламж авах
- ✓ Өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох
- ✓ Хувийн нууцаа хамгаалуулах
- ✓ Төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвөлгөө авах
- ✓ Хүчирхийлэлд өртсөн асуудлаараа лавлагаа авах
- ✓ Нэг цэгийн үйлчилгээний төвийн дотоод журмыг мөрдөх
- ✓ Ажилтнуудад хүндэтгэлтэй хандах

СЭДЭВ 7. ГЭР БҮЛИЙН БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх арга зүйг ойлгуулж, шаардлагатай маягтыг хөтлөх талаар мэдлэг олгох

Үндсэн ойлголт:

- ✓ Эрт илрүүлэлт
- ✓ Мэдээллийн сан

Олгох мэдлэг, ур чадвар:

- ✓ Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг эрт шатанд илрүүлэх
- ✓ Мэдээллийн сан бүрдүүлэх

Хүрэх үр дүн:

- ✓ Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг эрт шатанд илрүүлэх, маягтыг хөтлөх аргазүйд суралцана. Үйлчлүүлэгчдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэхийн ач холбогдлыг ойлгож, хохирогчийг хамгаалах арга хэмжээний хүртээмж сайжирна.

Хичээлийн агуулга:

- ✓ Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг хэрхэн илрүүлж байгаа талаар
- ✓ Илрүүлсэн тохиолдлыг хэрхэн бүртгэж байгаа талаар
- ✓ Бүртгэсэн тохиолдлуудыг хэрхэн дүгнэж байгаа талаар
- ✓ Маягтыг хэрхэн бөглөх талаар

Гол санаа:

- ✓ Ихэнх тохиолдолд хамтарсан багийн үйлчилгээ нь аман яриагаар явагддаг, хэдийгээр сум хороонд ажиллаж байгаа мэргэжилтнүүд хүчирхийллийн тохиолдлыг илрүүлсэн гэсэн баримт байдаггүйгээс ямар нэгэн эрсдэл гарах тохиолдол байдаг.
- ✓ Мөн нөгөө талаар үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хортой хохирол учрахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг.
- ✓ Үйлчлүүлэгчийнхээ асуудлыг тоймлон харахад ач холбогдолтой байдаг.
- ✓ Хүчирхийллийг даамжруулах, давтагдахаас урьдчилан сэргийлж чадна.
- ✓ Хамтарсан багийн кейс үйлчилгээний эхлэл үе шатны гол бичиг баримт мөн.

Хичээлийн явц:

Алхам 1: Маягтыг танилцуулах / маягтыг ашиглах дадлага ажил /

Алхам 2: Мэдээллийн сан бүрдүүлэх /лекц мэдээлэл/

Алхам 1. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг илрүүлэх маягт

Асуулт 1: Сүүлийн жилд та хэн нэгэнд зодуулж байсан уу? Тухайлбал
цохих, алгадах, өшиглөх г.м

Тийм

Үгүй

Тийм бол хэн? _____

Нийтдээ хэдэн удаа /давтамж/ _____

Асуулт 2. Та жирэмсэн байх үедээ хэн нэгэнд зодуулж байсан уу?

Тийм

Үгүй

Тийм бол хэн? _____

Нийтдээ хэдэн удаа /давтамж/ _____

Биеийн аль хэсэгт гэмтэл авч байсан бэ? Тоог дугуйлж, өгөгдлийн дор
зурна уу

1. Зэвсэг хэрэглэж айлгах
2. Алгадах, түлхэх, чирэх, үсдэх /гэмтсэн үү, эсхүл өвдөж байсан уу?/
3. Базах, чимхэх, өшиглөх, хөхрүүлэх, зүсэх г.м хэсэг өвдөлттэй байсан
4. Зодуулснаас яс хугарах, түлэгдэх, битүү бэртэлт авч байсан
5. Тархины гадны гэмтэл, тархины дотуур гэмтэл, тархи хөдлөх, байнга толгой өвдөх г.м
6. Зэвсэг /хутга, мэс, хайч, эд юмс/ хэрэглэж биед шарх, гэмтэл учруулж байсан


Асуулт 3: Та сүүлийн жил бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан уу?

Тийм

Үгүй

Тийм бол хэн? _____

Илрүүлэлт, хариу:



Хэрэв нэг удаа тийм гэж хариулсан бол НЦҮ-рүү илгээнэ.

Байгууллагын нэр:.....

Илрүүлсэн ажилтны овог нэр, албан тушаал:

Гарын үсэг

Үйлчлүүлэгчийн овог нэр

Дээрх маягтыг дэлгэрэнгүй танилцуулсны дараа

оролцогчдыг 2-оороо болгоод нэг нь үйлчлүүлэгч нэг нь хамтарсан багийн аль нэг гишүүн болж маягтыг бөглөж үзэхийг хүснэ.

Бөглөж дууссаны дараагаар оролцогчдоос чиглүүлэгч дараах асуултыг асууна.

- Маягтыг бөглөхөд ямар нэгэн хүндрэл байсан уу?
- Маягтыг бөглөхөд хэр хугацаа шаардагдаж байна вэ?

Алхам 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйл. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, 15 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, 21 дүгээр зүйл. “Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргүүдэд тус тус мэдээллийн сан бүрдүүлэх тухай зааж өгсөн байна. Мэдээллийн сан бүрдүүлэхдээ тухайн үйлчлүүлэгчийн талаар ерөнхий мэдээллийг /овог, нэр, оршин суугаа хаяг, хүчирхийлэгч хэн болох г.м/ бүртгэж аван өөрийн харьяалагдах байгууллагын чиг үүргийн дагуу мэдээллийн сан бүрдүүлэн ажиллана.” гэсэн заалтыг танилцуулна.

СЭДЭВ 8. ХОХИРОГЧТОЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ АРГА ТЕХНИК

Зорилго: Хохирогчийн нөхцөл байдал, эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчоос мэдүүлэг авах, ярилцлага хийх аргагүйг эзэмшүүлэх

Үндсэн ойлголт:

- Ярилцлага
- Мэдүүлэг
- Нөхцөл байдлын үнэлгээ

Олгох мэдлэг, ур чадвар:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ярилцлага хийх, мэдүүлэг авахад анхаарах
- Үйлчлүүлэгчийг хүндэтгэн харилцаж эерэг харилцааг бий болгох
- Нээлттэй асуулт асуух

Хүрэх үр дүн:

Хохирогчийн нөхцөл байдал, эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчоос мэдүүлэг авах, ярилцлага хийх аргагүйн талаар мэдээлэлтэй

болж, тусламж үйлчилгээний хүртээмж дээшлэх боломж бүрдэнэ.

Хичээлийн агуулга:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ярилцлага хийх, мэдүүлэг авах
- Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Хохирогчид үзүүлэх үйлчилгээ тасралтгүй байх нөхцөл ойлгуулах
- Гэр бүлийн хүчирхийллийн үйлчлүүлэгчийн нууцын тухай ойлголт өгөх

Гол санаа:

- Бэлгийн хүчирхийллийн хохирогч нь эмэгтэй бол түүнээс авах албан ёсны мэдүүлгийг болж өгвөл эмэгтэй мөрдөн байцаагч авах нь тохиромжтой гэж үздэг. Эрэгтэй хохирогч ирсэн тохиолдолд түүний нөхцөл байдлын онцлог, нас, хэрэгцээнээс шалтгаалан эмэгтэй, эрэгтэй байцаагчийн аль нэгийг нь сонгоно.
- Хохирогч хүүхдээс мэдүүлэг авах ярилцлагыг НЦҮ –ний нийгмийн ажилтан хийж, дүрс бичлэгт баримтжуулна.
- Цагдаагийн байгууллагын ажилтнууд хохирогч хүүхэдтэй ярилцлага хийх, мэдүүлэг авах үедээ энгийн хувцас өмсөх, мөн өрөөндөө хүүхдийн тоглоом байрлуулах нь хүүхдийг албархаг байдлаас гэрэвшин айж түгшихээс сэргийлэх чухал ач холбогдолтой.
- Ярилцлага хийхдээ хүүхэдтэй нөхөрсөг харьцаж, аюулгүй орчныг бүрдүүлэх ёстой бөгөөд асуулт нь энгийн үгээр илэрхийлэгдсэн хариулахад хялбар байхаас гадна өөрийг нь буруутгасан хандлага гарахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Хэрэв хүүхэд асуултанд хариулахгүй бэрхшээлтэй байвал НЦҮ-ний нийгмийн ажилтан, эсхүл түүний эцэг эх, асран хамгаалагчийг хамт байлцуулж болно. Ярилцлага хийх явцад хүүхдийн анхаарал сарниж, ядарч байгаа байдал ажиглагдвал түр завсарлаж амрах, мөн дараа нь үргэлжлүүлж болно.
- Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ гэдэг нь гэр бүлийн хүчирхийллийн түүхийг бичсэн үйл явцын тэмдэглэл, үйлчлүүлэгчид учирч болох аюулын түвшинг үнэлэх, хохирогч амь насаа алдахаас хамгаалах, анхааруулга өгөх үнэлгээний хуудас юм. Мөн хуулиар үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид, төрийн бус байгууллагын оролцоогхангахзахиргааны хуудас бөгөөд шинжээчийн дүгнэлт болдгоороо ач холбогдолтой юм.

- Нөхцөл байдлын үнэлгээ хийхээс өмнө үзүүлсэн үйлчилгээ болон үнэлгээ хийснээс хойш ямар үйлчилгээ, дэмжлэг хохирогчид хэрэгтэйг тодорхойлсон дэмжлэгийн хуудас юм.

Хичээлийн явц:

Алхам 1: Хохирогчтой ажиллах арга зүйн талаар мэдээлэл өгөх
Алхам 2: Дүрд тоглуулах

Алхам 1. Хохирогчтой ажиллах арга зүй

Хүчирхийлэгч хохирогчийг ихэнх тохиолдолд дагаж явдаг тул худал мэдээлэл өгөх, эмнэлэгт үзүүлэхдээ гэмтсэн шалтгаанаа өөрчилж хэлэх зэргээр эмчээс нуух тохиолдол гардаг. Тиймээс хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй, өртсөн, өртөх эрсдэлтэй хүнтэй мэдрэмжтэй хандаж цааш холбогдох байгууллагууд руу мэдээлэх нь чухал. Хохирогчийг хүчирхийлэгчээс тусгаарлан ганцаарчилсан үзлэг хийж, ярилцан үйл явцын тэмдэглэл бичин баримтжуулна. Хүүхдэд бүтэн биеийн үзлэгийг заавал хийнэ. Мөн хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсвэл өртсөн байж болзошгүй бол тохиолдол тусгаарлан ярилцана. Тэгэхдээ хүүхдийн насны онцлогт тохирсон байдлаар харилцаж, хүүхдийг ямарч тохиодолд буруутгахгүй байх ёстой.

Алхам 2. Дүрд тоглуулах

Оролцогчдыг хоёр хоёроор нь баг болгон мэргэжилтэн/эмч, үйлчлүүлэгч болгонд дүрд оруулж кейс өгнө. Тухайн үйлчлүүлэгч хүчирхийллийн талаар нууж байгаа харин мэргэжилтэн хэрхэн арга техник ашиглан илрүүлж зөв үйлчилгээ үзүүлэх талаар дүрд тоглоно. Ингэснээр бүлгийн хүмүүс практик мэдлэгтэй болгоно.

СЭДЭВ 9. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН АЮУЛЫН ЭРСДЛИЙН ТҮВШИН

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд Цагдаагийн байгууллага, алба хаагч “Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх” үүрэг хүлээсэн.

Тухайн хүний харъяалах цагдаагийн байгууллага дуудлагын дагуу очиж асуумж аван аюулын зэргийн үнэлгээг гаргаж аюулын зэрэг өндөр гарсан тохиолдол түр болон урт хугацааны хамгаалах байрлуу шилжүүлэн аюулгүй байдлыг хангана. Оролцогчдод аюулын зэргийн үнэлгээний хуудсыг танилцуулж, үр ашгийг ойлгуулна. Энэ талаар эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтан мэдээлэлтэй байх ёстой.

Зорилго: Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэл, нийгмийн орчны эрсдэл, хохирогчийн амь насыг хөнөөх магадлал бүхий эрсдлүүдийг тооцон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учрах аюулын эрсдлийн түвшинг тогтоох талаар мэдлэг олгох

Үндсэн ойлголт:

- Гэр бүлийн хүчирхийллийн нууц
- Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдлийн түвшин
- Хариу арга хэмжээ

Олгох мэдлэг, ур чадвар:

- Гэр бүлийн хүчирхийллийн нууцын талаар мэдлэг эзэмшинэ.
- Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдлийн түвшинг тогтоох ур чадвар эзэмшинэ.

Хүрэх үр дүн:

- Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдэд гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдлийн түвшинг тогтооно. Үйлчлүүлэгчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээ тодорхой болно.

Хичээлийн агуулга:

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюул учруулах эрсдлийн түвшинг үнэлэх аргачлал
- Эрсдлийн зэрэглэлийн ангилал

Гол санаа:

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учрах аюулын эрсдлийн түвшинг үнэлэхдээ хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэл, нийгмийн орчны эрсдэл, хохирогчийн амь насыг хөнөөх магадлал бүхий эрсдлүүдийг тооцно.
- Хохирогчид аюул учруулах эрсдлийн түвшинг бага, дунд, өндөр гэж ангилна.
- Асуултын тийм гэсэн хариулт тус бүр 1 оноо, харин үгүй гэсэн хариулт тус бүр 0 оноо гэж тооцогдоно.
- Түвшин бүрт тохирсон хариу арга хэмжээг авна.

Түвшин	Оноо	Онцгой тохиолдол:	Хариу авах арга хэмжээ:
Хохирогчид аюул учруулах эрсдлийн харьцангуй бага түвшин	Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд дангаараа 0-4 оноо болсон ЭСВЭЛ Нийгмийн орчны эрсдэлүүд дангаараа 0-3 оноо болсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшин харьцангуй бага гэж үнэлнэ	Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, хүчирхийлэл үйлдэгч гадны биет тухайлбал хутга мэс, галт зэвсэг хэрэглэдэг, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан нь нотлогдсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшинг аюул багатай гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бусад эрсдлийн хүчин зүйлсийн үзүүлэх дан ба хавсарсан нөлөөллийг нарийвчлан судалж, гэр бүлийн хүчирхийллийн даамжирсан нөхцөл байдлыг аюул учруулж болох дунд зэрэг буюу түүнээс өндөр эрсдэл байж болохыг тодорхойлно	Хохирогчийн шийдвэрийг нэн түрүүнд харгалзан үзэх ба нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэндийн үйлчилгээг санал болгоно. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн бусад гишүүд хохирогч өөрийн аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө боловсруулахад нь тусална. Нөгөө талаас орон нутгийн нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдах боломжоор хангана.

**“ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ОРОЛЦОО”**

<p>Хохирогчид аюул учруулах эрсдлийн дунд зэргийн түвшин</p>	<p>Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд ба нийгмийн орчны эрсдлүүдийн нийлбэр оноо 5-11 болсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын түвшинг дунд зэрэг гэж үнэлнэ.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, хүчирхийлэл үйлдэгч гаднын биет буюу галт зэвсэг хэрэглэдэг, хохирогч нэн даруй хүчний байгууллагын буюу нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй, эсвэл архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй улмаас хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай гэдэг нь тогтоогдсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын түвшинг дунд зэрэг гэж үзэхгүй. Энэ тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшинг өндөр гэж үзэн бусад хавсарсан нөлөөллийг нарийвчлан судлах шаардлагатай.</p>	<p>Хохирогчийн хүсэлтийг харгалзан гэрт нь буцаах буюу хүчирхийлэл үйлдэгчтэй хамт байх шийдвэрийг нь хүндэтгэж үзэх хэдий ч орон нутгийн цагдаагийн байгууллага ба нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд хохирогчийн нөхцөл байдлыг хяналтандаа авах арга хэмжээ авна. Нөгөө талаас ах дүү, төрөл садан болон хөршийн хамгаалалтыг санал болгоно. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн бусад гишүүд хохирогч өөрийн аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө боловсруулахад нь тусална.</p>
<p>Хохирогчид аюул учруулах эрсдлийн өндөр түвшин</p>	<p>Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд нь нийгмийн орчны эрсдэлүүд ба хохирогчийг алах магадлал бүхий эрсдлүүдийн аль нэгэнтэй хавсарсан</p> <p>ЭСВЭЛ</p> <p>Гурван бүлгийн эрсдлүүд хавсарсан хэлбэрээр зэрэг илэрсэн тохиолдолд тэдгээрийн нийлбэр оноо нь 12 буюу түүнээс их болсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшин өндөр буюу аюултай гэж үнэлнэ.</p>	<p align="center">-</p>	<p>Энэ тохиолдолд хохирогчийг шууд хөндлөнгийн хамгаалалтанд авах ба хүчирхийлэл үйлдэгчид шүүхээр эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтийг гаргана. Мөн хохирогчийн хүсэлтийг харгалзан хуулийн байгууллагаар шийдвэрлэх асуудлуудыг тогтооно. Хохирогчийг нэн даруй хамгаалах арга хэмжээг төлөвлөж холбогдох нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэндийн байгууллагуудтай холбон зуучлана.</p>

Хичээлийн явц:

Алхам 1: Мэдээллийг power point-оор танилцуулах

Алхам 2: Оролцогчдын эрсдлийн талаарх мэдлэгийг сорьж асуулт асууж хариулна.

Алхам 1. Мэдээлэл өгөх

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүргийн талаар “Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх” талаар танилцуулна.

Алхам 2. Оролцогчдод эрсдлийн талаар мэдээллийг өгсний дараа баталгаажуулах асуулт асууна.

- Аюулын зэргийн үнэлгээний хуульд заасан байдал
- Аюулын зэргийн үнэлгээг хэн хийх вэ
- Үнэлгээний үр ашиг, ач холбогдол
- Үнэлгээг хийсний дараах үйлчилгээ г.м

СЭДЭВ 10. ТОХИОЛДОЛ/КЕЙС/-ЫН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлын удирдлагын төлөвлөгөө боловсруулах аргазүйн талаар мэдлэг олгох

Үндсэн ойлголт:

- Тохиолдол/кейс/
- Тохиолдлын удирдлагын төлөвлөгөө
- Тохиолдлын үед авах арга хэмжээ
- Үйл явцын тэмдэглэл

Олгох мэдлэг, ур чадвар:

- Тохиолдлын удирдлагын төлөвлөгөө боловсруулах
- Тохиолдлын үед авах арга хэмжээ

Хүрэх үр дүн:

- Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг эрт шатанд илрүүлэх аргазүй, маягтыг хөтлөх аргазүйд суралцана. Үйлчлүүлэгчдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэхийн ач холбогдлыг ойлгож, хохирогчийг хамгаалах арга хэмжээний хүртээмж сайжирна.

Хичээлийн агуулга:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг хэрхэн илрүүлж байгаа талаар
- Илрүүлсэн тохиолдлыг хэрхэн бүртгэж байгаа талаар
- Бүртгэсэн тохиолдлуудад хэрхэн дүгнэж байгаа талаар
- Маягтыг хэрхэн бөглөх талаар

Гол санаа:

- Тохиолдол гэдэг нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг хэлнэ.
- Тохиолдлын удирдлага нь хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх бүхий л үйл явцыг хамруулсан үе шат бүхий үйл ажиллагааг хэлнэ.
- **Кейс нээх:** Хүчирхийллийн тохиолдлыг илрүүлсэн, үйлчлүүлэгчийн анхны бүртгэл болон үйлчлүүлэгчийн амьдралын түүхийг багтаасан хавтас болон үйлчлүүлэгчтэй зөвлөлдсөний үндсэн дээр үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон үйлчилгээний эхлэл үе юм.
- **Кейс төлөвлөгөө:** Хамтарсан баг нь үйлчлүүлэгчтэй хамтран үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нарийвчлан төлөвлөсөн төлөвлөгөө. Үйлчлүүлэгчийн оролцоог бүх төлөвлөлтөд оролцуулна.
- **Кейс үйлчилгээг үзүүлэх:** Үйлчилгээг төлөвлөгөөний дагуу үзүүлэх үйл явц. Үйлчлүүлэгчийн оролцоог хангаж үйлчлүүлэгчтэй холбоотой шийдвэрийг үйлчлүүлэгчээс заавал асууж баталгаажуулж гаргана.

- **Үйл явцын тэмдэглэл:** Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлага болон үйлчилгээ үзүүлж байх явцад хийж байгаа тэмдэглэлүүдийг хэлнэ. Үйл явцын тэмдэглэл хөтөлснөөр үйлчлүүлэгчтэй холбоотой хийсэн бүхий л үйл ажиллагааг баримтжуулж баталгаажуулна. Үйлчлүүлэгчтэй холбоотой ямар нэгэн эрсдлээс хамгаалах баримт бичиг болно.
- **Кейс хаах, үнэлэх:** Үзүүлсэн үйлчилгээ үр дүнтэй болсон эсэхийг үнэлэж үйлчилгээг төгсгөх үе шат юм. Кейс хаахдаа үйлчлүүлэгчид урьдчилан мэдээлнэ. Кейс төлөвлөгөө хэрхэн биелэгдсэн талаар үнэлгээ дүгнэлт өгнө.

Хичээлийн явц:

Уг сэдэв нь 2 алхамтай. Лекц танилцуулга болон өгөгдсөн кейсийн дагуу дадлага ажил хийнэ.

Алхам 1: Лекц мэдээллийг power point-оор танилцуулах

Алхам 2: Өгөгдсөн кейсийн дагуу бүлгээр ажиллаж кейс төлөвлөгөө боловсруулах дадлага ажил хийнэ.

Алхам 1: Чиглүүлэгч дараах гол ойлголтуудыг оролцогчид өгнө. Үүнд: Нийгмийн ажлын практикт тодорхой кейсийн хүрээнд үйлчилгээг хүргэх, зохицуулах, холбогдох шийдвэр гаргах үйл явцыг кейс менежмент гэнэ. Кейс менежментийн аргыг ашиглах зорилго нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийг шаардлагатай үйлчилгээнд холбож, үйлчилгээг хүргэж буй үйл явцыг зохицуулах замаар хувь хүн, хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээний тасралтгүй чанарыг хангахад оршино. Кейс менежментийн 3 үндсэн үүрэг:

- Үйлчлүүлэгчийн цогц хэрэгцээг ойлгож мэдэх /нэн тэргүүний материаллаг хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ, сэтгэл санааны хэрэгцээ/
- Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, нөөцөд үйлчлүүлэгчийг холбох
- Үйлчилгээний үр дүнг хангах үүднээс хяналт тавих үйл ажиллагаа болно.

Алхам 2: Оролцогчдыг бүлгүүдэд хувааж, хамтарсан багийн гишүүдээс бүрдсэн дүрд орж, урьдчилан бэлтгэсэн 2 кейсийг ашиглан кейс менежментийн төлөвлөгөө боловсруулна.

Бүлгийн ажил хийхдээ анхаарах зүйл:

- Бүлгийн ажилд бүх гишүүд идэвхтэй оролцоно.
- Үйлчилгээг төлөвлөхдөө хууль болон бусад холбоотой баримт бичгүүдийг ашиглахыг зөвлөнө.

СЭДЭВ 11. ГЭР БҮЛИЙН БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧТОЙ АЖИЛЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллахад эмч, эмнэлгийн ажилтнуудын бэлтгэл ажлын талаар мэдлэг олгох

Үндсэн ойлголт:

- Эмч, эмнэлгийн ажилтнууд
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч
- Эрүүл мэндийн үзлэг

Олгох мэдлэг, ур чадвар:

- Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг эрт шатанд илрүүлэх, мэдээлэх бэлтгэл
- Үзлэгийн үед баримтлах дэг журам

Хүрэх үр дүн

- Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг эрт шатанд илрүүлэх аргагүй, мөрдөх стандартын талаар мэдлэгтэй болж, үйлчлүүлэгчдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэхийн ач холбогдлыг ойлгож, хохирогчийг хамгаалах арга хэмжээний хүртээмж сайжирна.

Хичээлийн агуулга:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэх, бүртгэх
- Хохирогчид эрүүл мэндийн үзлэг хийх тухай

Гол санаа:

- Хохирогчийг илрүүлэх, мэдээлэх үүрэг ГБХТТ хуульд туссан байдаг.
- Эрүүл мэндийн үзлэг хийх хохирлын байдлыг тодорхойлох нь нэн чухал.
- Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэлийг хянуур, нягт нямбай хангасан байх ёстой. Эрүүл мэндийн ажилтан нь (эмч, сувилагч, туслах ажилтан) зохих дадлага туршлага, багаж тоног төхөөрөмж, материал хангалттай байх ёстой.
- Үйлчилгээ үзүүлэхэд дараах асуудлыг анхаарч стандарт дүрэм журмыг баримтлах нь чухал:
 - Зодуулсан, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх ямар үйлчилгээ үзүүлж болохыг мэддэг байх
 - Нарийн мэргэжлийн ямар эмчид илгээх талаар мэддэг байх
 - Үйлчлүүлэгчийн эрх, аюулгүй байдал, нууцлал, нэр төрийг хэрхэн хамгаалах талаар мэддэг байх
 - Ийм төрлийн үйлчилгээ 7 хоногийн 24 цагийн турш нээлттэй байх

Хичээлийн явц:

Уг сэдэв нь 2 алхамтай. Хэрэглэгдэх аргууд нь лекц мэдээлэл, бүлгийн ажил,

Алхам 1: Лекц мэдээллийг power point-оор танилцуулах

Алхам 2: Бүлгээр ажиллаж, эмнэлгийн ажилтны үүрэг, бэлтгэлийг бичүүлнэ.

Алхам 1.Эмнэлгийн ажилтнуудын мэдвэл зохих зүйлс:

- Эрүүл мэндийн байгууллагын аль ч ажилтан үйлчлүүлэгчид ямар төрлийн үйлчилгээ халамж үзүүлж болох, хэрэв хүчингийн хэргийн талаар мэдээлэх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй эмч, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эсхүл албан бичиг, баримтжуулалт хөтлөх эрхтэй;
- Шүүх эмнэлгийн нотолгоо, баримттай холбоотой хуулийн ямар заавар журам байдаг;
- Хүчингийн гэмт хэргийг мэдээлэхтэй холбоотой журам зааврыг мэдэх;
- Уг гэмт хэрэг эрүүл мэндэд учрах хор хохирол, түүнийг арилгахтай холбоотой ажлыг зохион байгуулах (жирэмслэлт, үр хөндүүлэх ДОХ шинжилгээ хийлгэх, урьдчилан сэргийлэх ямар хууль тогтоомж байдаг тухай)

Нөөц бололцоо:

- Шинжилгээ явуулахад шаардагдах ямар ямар техник хэрэгсэл байгаа, фосфатын хүчил, БЗДХ,ДОХ шинжилгээ хийх лабораторийн боломж, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх ямар боломж байгаа эсэх
- Бэлгийн замын халдварт өвчин, хожуу илрэхээс урьдчилан сэргийлэх (PEP), дархлаажуулалтын хуваарь, ямар вакцинууд хийх боломжтой эсэх
- Хүчингийн хэргийн хохирогчид хоёрдугаар шатны үйлчилгээ үзүүлэх боломжтой эсэх (зөвлөгөө өгөх, мэс засал, эмэгтэйчүүд, хүүхэд)

Шаардагдах зүйлс:

- Үйлчлүүлэгчийг нэгээс нөгөө газар руу олон дахин явуулахгүйн тулд эмнэлгийн бүх үйлчилгээ төвлөрсөн газарт эмчилгээ, үйлчилгээ явуулах шаардлагатай.
- Эмнэлгийн үйлчилгээ 7 хоногийн 24 цагийн турш бэлэн байх ёстой.
- Шаардагдах материал, тоног төхөөрөмжийг тусгай хайрцаг саванд бэлэн байлгах хэрэгтэй.
- Бусад эмнэлэг болон НЦҮ -тэй хамтран ажиллах ёстой.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогчид чанартай, бүрэн цогц үйлчилгээ үзүүлэх нөхцлийг хангахын тулд байгууллага, салбар хоорондын үйл ажиллагааны нэгдлийг хангах шаардлагатай.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэл шат

1.Заавар	Байгаа эсэх
Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны заавар журам*	
2.Мэргэшсэн мэргэжилтэн	
Орон нутгийн эмнэлгийн байгууллагын тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтнүүд (24 цагийн турш)	
Эмэгтэй (үйлчлүүлэгчтэй ижил хүйсийн) эмнэлгийн байх шаардлагатай. Хэрэв ийм боломжгүй бол хохирогчид эмнэлгийн үзлэг хийх өрөөнд эмэгтэй хүн байлгах хэрэгтэй *	
3.Тавилга хэрэгсэл, байр	
Өрөө (нэг хүний, чимээгүй, тайван, дотроо бие засах болон угаалгын өрөөтэй)*	
Үзлэгийн ширээ, ор *	
Чийдэн, аль болох хананд байрлуулсан	
(шууд тусах гэрэл, ялангуяа хүүхдэд айдас төрүүлдэг)*	
Томруулдаг шил	
Ариутгах хэрэгсэл *	
Лабораторийн хэрэгсэл, микрокоп, мэргэжлийн лаборант бэлэн байх	
Жинлүүр, хүүхдийн өндөр хэмжих хэрэгсэл	
4.Бусад хэрэгслүүд	
Хүчингийн хохирогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хайрцагт шүүх эмнэлгийн нотолгоог цуглуулах дараах хэрэгслүүд байх шаардлагатай	
Толь (зөвхөн нэг удаагийн, хуванцар, насанд хүрэгчдэд зориулсан байна)	
Умдагны үснээс гадны зүйл олж тогтооход зориулагдсан тусгай сам	
Тариур, зүү, (хүүхдэд эрвээхэй зүү, цус авах хуруу шил)	
Эр бэлгийн эс илрүүлэх шилэн ялтас	
Наалдац авах хөвөн оройтой түүдэг, наалт, самбай	
Наалдац авсан түүдгийг авч явах лабораторийн сав	
Үйлчлүүлэгч хувцсаа тайлах үед гадны зүйл цуглуулах нэг удаагийн цаасан дэвсгэр	
Шарах, урагдалтыг хэмжих туузан хэмжигч*	
Нотолгоо цуглуулж хийх цаасан уут *	
Уут, саванд наах шошго*	
Хамгаалалтын хэрэгсэл (хурц шовх үзүүртэй эсвэл халдвартай зүйлийг хийх хайрцаг бээлий, саван) *	
Сэхээн амьдруулах хэрэгсэл *	
Урагдалтыг тогтоох эмнэлгийн оёдол тавих хэрэгслүүд	
Зүү тариур *	
Халат (бүтээлэг, дэвсгэр даавуу) эмнэлгийн үзлэгийн үеэр үйлчлүүлэгчийг хучих хучлага *	
Хэргийн нотлох баримтанд урагдсан, бохирдсон хувцыг авсаны дараа сольж өмсгөх хувцас	

“ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ОРОЛЦОО”

Ариун цэврийн хэрэгсэл (хөвөн, даавуу) *	
Жирэмсний тест	
Жирэмслэлтийн хугацааг тооцох диск	
5. Эм	
БЗДХ –ийг эмчлэх *	
ДОХ –хожуу илрэлээс урьдчилан сэргийлэх, эмчлэх	
Жирэмслэлт, үр тогтохоос хамгаалах, урьдчидан сэргийдэх эм, зэсэн бүрхүүлтэй үтрээнд тавих ерөндөг*	
Тетанус токсойд, тетанус иммуноглобулин	
Элэгний В вирусын эсрэг вакцин	
Өвчин намдаах (парацетомол) *	
Тайвшруулах эм	
Хүүхдэд зориулагдсан тайвшруулах эм	
Оёдол тавихад хэсэгчилэн мэдээ алдуулах эм *	
Шарх эмчилэх антибиотик *	
6. Бусад хэрэгслүүд	
Эмнэлгийн хүснэгт, бүдүүвч зураг *	
Хүчингийн дараа эмнэлгийн халамж үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэл хөтлөх хүснэгт	
Хүчингийн хохирогчид эмчилгээ хийсэн мэдэгдэх хуудас *	
Нууц, хувийн чанартай тэмдэглэл бичсэн бичиг баримтыг хадгалах цоожтой сав *	

*Ард нь од тавьсан зүйлс нь бэлгийн хүчирхийллийн хохирогчид эмнэлгийн тусламж үзүүлэх, шинжилгээ хийхэд шаардагдах хамгийн анхан шатны зүйлс юм.

Алхам 2. Эмнэлгийн ажилтны үүрэг, мэдвэл зохих зүйлийн талаар хоёр бүлэгт хуваан ажиллуулна.

- Эмч хэрхэн илрүүлэх вэ
- Илрүүлсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ
- Гэр бүлийн хүчирхийлэлд эмчийн үүрэг
- Хохирогч хүүхдэд эмч хэрхэн үзлэг хийж ярилцаж, хааш нь мэдээлж холбон зуучлах вэ
- Насанд хүрсэн хохирогчтой хэрхэн ажиллах вэ
- Хохирогчтой хэрхэн ярилцаж илрүүлэх вэ
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг мэдээлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээх вэ г.м асуултыг баг тус бүрт тавьж 15 минутын дараа нөгөө багтаа танилцуулж харилцан ярилцах байдлаар бүлгээр ажиллана.

СЭДЭВ 12: БАРИМТЖУУЛАЛТ ХИЙХ, НОТЛОХ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх явцад нотлох баримт бүрдүүлэх талаар мэдлэг олгох

Үндсэн ойлголт:

- Баримтжуулалт
- Нотлох баримт

Олгох мэдлэг, ур чадвар:

- Баримтжуулалтын төрөл
- Баримтжуулалтын арга

Хүрэх үр дүн:

- Хүчирхийлэлд өртсөн хохирогчид үйлчилгээ үзүүлэх явцад нотлох баримт бүрдүүлэх аргазүйд суралцана. Баримтжуулалтын аргуудыг мэдэж авна.

Хичээлийн агуулга:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлын баримтжуулалтын төрөл
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлын баримтжуулалтад ашиглах арга
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэхэд баримтжуулалт хийхэд анхаарах зүйлс

Гол санаа:

- Баримтжуулалтын төрөл
 - Үйл явцын тэмдэглэл хөтлөх
 - Фото зураг
 - Гар бичмэл
 - Дуу хураагчид хураах
 - Видео бичлэг
 - Бусад
- Баримтжуулах арга
 - **Хохирогчтой хийсэн ярилцлагыг баримтжуулах:** Дектофонд бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх, хохирогчоор өөрөөр нь хүчирхийллийн түүхийг бичүүлэх
 - **Гэрчийн мэдүүлэг авах:** Хөршөөс, найз нөхдөөс, гэр бүлийн гишүүдээс, ажлын хамт олноос
 - **Цагдаад өгсөн дуудлага:** Гэр орондоо согтуугаар хүчирхийлэл үйлдэж удаа дараа эрүүлжүүлэгдэж байсан буюу захиргааны арга хэмжээ авагдаж байсан талаарх бүртгэл. Захиргааны журмаар арга хэмжээ авагдаж байгаагүй боловч байнгын хүчирхийлэл

дарамтад байсны улмаас удаа дараа цагдаагийн байгууллагад дуудлага өгч, гомдол гаргаж байсан талаарх мэдээлэл. Оршин суудаг газартаа байнгын хүчирхийлэл буюу зөрчил маргаантай байдаг эсэх талаарх бүртгэл. Хүчирхийлэл үйлдэгдсэн газрын байдал, тэндээс олдсон эд зүйл, баримт сэлт



Үйл явцын тэмдэглэл хөтлөх:



Баримт бичиг бүрдүүлэх, хадгалах:



Фото баримтжуулалт:



Бичлэг (утасны яриа, аудио)

- ✓ Фото баримтжуулалт
 - Биеийн аль хэсэгт, ямар ямар бэртэл гэмтэл учирсан байсан талаар бичиж баримтжуулна.
 - Бэртэл гэмтлийн байдлыг фото зургаар баримтжуулахдаа эхэлж заавал бүтэн биеэр нь зургийг нь авч, дараа нь тухайн бэртэж гэмтсэн хэсгийг хэсэгчлэн авна.
 - Бэртэл, гэмтлийг фото зургаар баталгаажуулна.
 - Дижитал аппаратаар авсан зурагт засвар хийж болдог гэдгээрээ нотлох баримтын хэмжээнд үнэлэгддэггүй.
 - Баримтжуулалт хийсэн талаараа хохирогчийн биеийн аль хэсгийн гэмтлийг харуулсан зураг, баримтжуулсан өдөр зэргийг зөвлөгчийн бүртгэлийн дэвтэрт заавал бичиж тэмдэглэнэ.
 - Фото зургийг авсан он, сар, өдрийг зургийн аль нэг хэсэгт гаргасан байна.

Хичээлийн явц:

Уг сэдэв нь 2 алхамтай. Хэрэглэгдэх аргууд нь лекц мэдээлэл, бүлгийн ажил,

Алхам 1: Лекц мэдээллийг power point-оор танилцуулах

Алхам 2: Бүлгээр ажиллах

Алхам 1. Баримтжуулалтын талаар мэдээлэл өгөх

Тухайн хохирогчийг ирэхэд батлагдсан маягтын дагуу асууж бүртгэж

авна. Шаардлагатай тохиолдолд биеийн зураг болон нарийн шинжилгээний /рентген, эхо, КТГ гэх мэт/хариу зургуудыг бүртгэлийн маягттай хавсарган нотлох баримтыг бүрдүүлэн баримтжуулна.

Алхам 2.Оролцогчдыг 2 бүлэгт хуваана. 1 дүгээр бүлэгт - нотолгоонд багтах зүйлсийг тоочих, 2 дугаар бүлэгт баримтжуулах арга гэсэн сэдэв өгч

СЭДЭВ 13. ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилго: Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг холбон зуучлах үйлчилгээнд хамруулах, үүнийг баримтжуулах талаар мэдлэг олгох

Үндсэн ойлголт:

- ✓ Холбон зуучлах үйлчилгээ
- ✓ Холбон зуучлах үйлчилгээний үе шат
- ✓ Баримтжуулалт
- ✓ Илгээх хуудас

Олгох мэдлэг, ур чадвар:

- ✓ Холбон зуучлах үйлчилгээг хэрхэн зохион байгуулах
- ✓ Хохирогчийн нөхцөл байдал буюу хэрэгцээг үнэлэх
- ✓ Хохирогчид хэрэгцээтэй үйлчилгээ, нөөц боломжийг судлах
- ✓ Хохирогчийг үйлчилгээ, нөөцтэй холбож өгөх
- ✓ Үйлчилгээний чанарт хяналт тавих, эргэх холбоотой байх

Хүрэх үр дүн:

- ✓ Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг холбон зуучлах үйлчилгээнд хамруулах аргазүйд суралцана.

Хичээлийн агуулга:

- ✓ Холбон зуучлах үйлчилгээ гэж юу вэ?
- ✓ Холбон зуучлах үйлчилгээг хэрхэн хийж гүйцэтгэх вэ?
- ✓ Холбон зуучлах үйлчилгээг хэрхэн дүгнэх вэ?
- ✓ Холбон зуучлах үйлчилгээнд хамруулах ИЛГЭЭХ ХУУДАС, БУЦААХ ХУУДАС хэрхэн ашиглах вэ?

Гол санаа:

- ✓ Холбон зуучлах гэдгийг “гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ” гэж хуульчилсан
- ✓ Холбон зуучлах үйлчилгээ гэдэг нь хохирогчийн хэрэгцээт үйлчилгээ, нийгмийн нөөцтэй нь холбож өгөхөд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ юм.
- ✓ Үйлчлүүлэгч болон түүний орчны нөөц боломжийн хоорондын харилцаа холбоог дэмжин идэвхжүүлэхэд оршдог.

- ✓ Холбон зуучлах үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн үр дүнтэй нийгмийн үйлчилгээ, нөөцөд холбож өгөх зорилготой.
- ✓ Холбон зуучлах үйлчилгээний үе шат:

Хохирогчийн нөхцөл байдал буюу хэрэгцээг үнэлэх

- Хүчирхийллийн улмаас хохирогчийн ямар эрхүүд зөрчигдсөн, ямар хэрэгцээ тулгараад байгааг үнэлнэ.

Хохирогчид хэрэгцээтэй үйлчилгээ, нөөц боломжийг судлах

- Хохирогчид шаардлагатай үйлчилгээг хүргэх байгууллагуудын талаар судлах, мэдээллийн сан бүрдүүлэх.

Хохирогчийг үйлчилгээ, нөөцтэй холбож өгөх

- Хохирогчид хамгийн үр дүнтэй, шуурхайг, мэргэжлийн үйлчилгээг хүргэх үйлчилгээ, нөөцийг сонгож тухайн байгууллагатай үйлчлүүлэгчийг холбож өгнө.

Үйлчилгээний чанарт хяналт тавих, эргэх холбоотой байх

- Хохирогчид шаардлагатай үйлчилгээг хүргэж буй талууд буюу илгээгч болон хүлээн авагч байгууллагууд холотой ажиллана. Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг хүргэж чадаж байгаа эсэх, үр дүн нь ямар байгаа талаар хяналт, мэдээлэлтэй байна.

- Холбон зуучлах үйлчилгээний үнэлгээ дүгнэлт нэн чухал бөгөөд Холбон зуучилсан байгууллагатайгаа эргэх холбоотой байхыг хэлнэ.
- Холбон зуучлах үйлчилгээний эргэх холбоог дараах байдлаар зохион байгуулж болно.
 - Эргэж холбогдож байх нь тухайн байгууллага үйлчилгээгээ чанартай үзүүлэхэд нь нөлөөлж байдаг. (Хохирогч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хамтарсан уулзалт хийх)
 - Үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд болон үйлчлүүлэгч хамтарсан уулзалтыг хийж, ямар зорилго, оролцоотойгоор хэрхэн харилцан уялдаатай ажиллах талаар нэгдсэн ойлголтод хүрэх хэрэгтэй. (Хохирогчийн санал, сэтгэгдлийг сонсох)
 - Хэрэв хохирогчийн хэрэгцээнд нийцээгүй, үр дүнгүй, ёс зүйгүй үйлчилгээ үзүүлж байвал сайжруулах талаар тодорхой алхмууд хийх, эсвэл үйлчилгээг зогсоох зэрэг арга хэмжээнүүдийг авч болно.
- Холбон зуучлах хуудсыг зайлшгүй ашиглах шаардлагатай бөгөөд үнэн зөв, гаргацтай бөглөсөн байх шаардлагатай.
- Холбон зуучлах хуудас нь ИЛГЭЭХ, БУЦААХ гэсэн 2 хэсэгтэй байна.

1. Үйлчилгээнд холбон зуучлагч байгууллага

2. Үйлчилгээг хүсч, хандаж байгаа байгууллага

3. Үйлчлүүлэгчийн овог нэр

4. Үйлчлүүлэгчтэй холбоо барих утас, хаяг

5. Кейсийн дугаар (код)

6. Холбон зуучлах үндэслэл: хүчирхийллээс сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох үүргийн тань дагуу хохирогч-ний аюулгүй байдлыг хангуулах, шаардлагатай бусад ажиллагаа хийлгэхээр холбон зуучилж байна.

7. Хүчирхийллийн хэлбэр

8. Кейсийн тухай товч тэмдэглэл:

9. Түүнд туслах гэр бүлийн болон холбогдох бусад хүмүүсийн нэр, хаяг утас:

10. Үйлчилгээ үзүүлж буй бусад байгууллагууд:

Нэр

Хаяг

Утас

Үйлчилгээний төрөл

Нэр

Холбон зуучилсан ажилтны гарын үсэг:

Хүлээн авсан цагдаагийн ажилтны нэр, албан тушаал, гарын үсэг

_____ / _____ /

*Үйлчилгээнд холбон зуучилсанон сар
өдөр*

Б.Буцаах хуудас

Хүлээн авагч байгууллагын зүгээс үзүүлсэн үйлчилгээний тухай тэмдэглэгээ

Өнөөгийн нөхцөл байдал

Цаашид авах арга хэмжээ

Бусад зөвлөмж, тайлбар

Үйлчилгээ үзүүлж, тэмдэглэл хөтөлсөн ажилтны нэр, албан тушаал, гарын үсэг

Хуудас буцаасанонсарөдөр

Хуудас хүлээн авсанонсарөдөр

ТЭМДЭГЛЭЛ
